

Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 8
дугаар сарын 6-ны өдрийн 439/ 01/86 тоот тушаалын
хавсралт

Монгол Улсын төлбөрийн тэнцлийг зохиох аргачлал

**Улаанбаатар хот
2009**

Гарчиг

Нэг. Нийтлэг үндэслэл	3
Хоёр. Ойлголт, тодорхойлолт	3
Гурав. Төлбөрийн тэнцлийн ажил гүйлгээг бүртгэх зарчим	5
Дөрөв. Ажил гүйлгээ, актив, пассивын үлдэгдлийн үнэлгээ	5
Тав. Тэнцэлд ашиглагдах ангилал	6
Зургаа. Тайлангийн хугацаа	7
Долоо. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлт, түүний бүрэлдэхүүн хэсэг	8
I. Урсгал данс	8
А. Бараа болон үйлчилгээ	10
Б. Орлого	26
В. Урсгал шилжүүлэг	30
II. Хөрөнгө ба санхүүгийн данс	33
А. Хөрөнгийн данс	35
Б. Санхүүгийн данс	39
III. Цэвэр нөөцийн өөрчлөлт	49
Найм. Үндэсний тооцооны систем ба Төлбөрийн тэнцэл	50
Хавсралт 1. Төлбөрийн тэнцэл, түүний стандарт үзүүлэлт	52
Хавсралт 2. Төлбөрийн тэнцлийн хураангуй хүснэгт	55
Хавсралт 3. Төлбөрийн тэнцлийг зохиоход шаардлагатай статистикийн мэдээлэл	57
Хавсралт 4. Төлбөрийн тэнцлийг зохиоход шаардагдах судалгааны жагсаалт	64

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Төлбөрийн тэнцэл нь Монгол Улсаас гадаад орнуудтай тайлант хугацаанд гадаад худалдаа, эдийн засгийн бусад харилцааны талаарх хийсэн төлбөр тооцооны гүйлгээг нэгтгэн харуулдаг статистикийн хүснэгт юм.
- 1.2. Төлбөрийн тэнцлийг Монгол Улсын төдийгүй олон улсын түвшинд бодлого боловсруулахад ашиглана. Түүнчлэн, гадаад төлбөрийн тэнцлийн баланслагдаагүй шалтгааныг тодорхойлох, барааны худалдаа, шууд хөрөнгө оруулалтын уялдаа, олон улсын үйлчилгээний гадаад худалдааны төлөв байдал, гадаад өрийн асуудал зэрэгт дүн шинжилгээ хийх чухал хэрэгсэл мөн юм.
- 1.3. Монгол Улсын гадаад төлбөрийн тэнцлийн агуулга, ойлголт, тодорхойлолт, түүний статистикийн үзүүлэлтүүдийг тодорхойлж, тэнцлийг зохиох, үйл ажиллагааг нэгтгэхэд энэхүү аргачлалын зорилго оршино.

Хоёр. Ойлголт, тодорхойлолт

"Төлбөрийн тэнцэл" гэж тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалын орлого, зарлагын гүйлгээг системчлэн нэгтгэсэн статистикийн тайланг хэлнэ.

Энэ аргачлалд тусгагдсан нэр томъёог дараах байдлаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:

2.1. Эдийн засгийн харьяат нэгж

- 2.2.1. **Эдийн засгийн нутаг дэвсгэр** гэж Монгол Улсын засгийн газрын удирдлагын дор хүн ам чөлөөтэй зорчин, бараа, үйлчилгээ, хөрөнгөө гүйлгээнд чөлөөтэй оруулж болох нутаг дэвсгэрийг; тухайлбал: (а) агаарын зай, гол ус, гадаад далай дахь тухайн улсын мэдлийн хэсэг (загас агнуур, далайн гүнээс шатахуун, эрдэс ашиглахтай холбоотой эрх); (б) гадаад орнуудад байгаа тухайн улсын эзэмшлийн нутаг дэвсгэр; (в) гаалийн хяналтын дор үйл ажиллагаагаа явуулдаг аливаа чөлөөт бүс, баталгаат агуулах, эсвэл далай тэнгисийн загас агнуурын үйлдвэр (эдгээр нь тухайн улсын эдийн засгийн нутаг дэвсгэрийн зарим хэсгийг бүрдүүлдэг хэсэгт байршсан байна)-ийн газрыг хамруулна. Эдийн засгийн нутаг дэвсгэрт чөлөөт бүс, баталгаат агуулах эсвэл гаалийн хяналтын дор хийгдэх далай тэнгист үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрийн газар мөн багтана.
- 2.2.2. **Эдийн засгийн сонирхлын төвтэй** гэж тухайн субъект эдийн засгийн нутаг дэвсгэр дээр орон сууц, үйлдвэр, үйлчилгээний газар, байгууламж зэргийг өмчилдөг, эрдэс баялгийн нөөц ашиглаж, орлого олох зэрэг үйл ажиллагаа явуулж байгааг;
- 2.2.3. **Эдийн засгийн харьяат (цаашид харьяат)** гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа Монгол улсын иргэд, гадаад

оронд 1 жил хүртэлх хугацаагаар түр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд, Монгол улсын нутаг дэвсгэр дээр 1 жилээс дээш хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсаас гадаад орнуудад суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол Улсын иргэд, цэргийн албан хаагч гэр бүлийн гишүүдийн хамт, гадаад оронд сурч байгаа болон гадаадад урт, богино хугацаагаар эмчлүүлж байгаа Монгол Улсын иргэдийг;

2.2.4. **Үйлдвэрийн газар** гэж өөрийн хүчин чадлаараа бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэгч байгууллагын бүтэцтэй нэгжийг;

- Үйлдвэрийн газар нь байгууллагын бүтэцтэй нэгжийн хамгийн доод түвшний нэгдэл бөгөөд өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай бүхий л үүрэг хариуцлагаа бие даан хүлээж, шууд ба шууд биш байдлаар хяналт тавьж ажиллана.
- Үйлдвэрийн газар нь хоршоолсон корпораци, квази корпораци, ашгийн бус байгууллага эсвэл хоршоолоогүй үйлдвэрийн газар байж болно.
- “Хөдөлгөөнт тоног төхөөрөмжөөр үйл ажиллагаа явуулдаг нэгж” нь олон улсын ус, агаарын замд эсвэл бусад эдийн засагт үйл ажиллагаа явуулдаг байж болно. Энд төрийн далбаа түрээслэх үйл ажиллагаа багтана.

2.2.5. **Эдийн засгийн харьяат бус (цаашид харьяат бус)** гэж 2.2.3-т үл хамрагдах гадаад орны болон Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг;

- 2.2. **Зах зээлийн үнэ** гэж ямар нэгэн зүйлийг борлуулах хүсэлтэй байгаа худалдаачдаас уг зүйлийг худалдан авахаар худалдан авагчдаас төлж буй мөнгөний тоо хэмжээг;
- 2.3. **ФОБ нөхцлийн үнэ** (хил хүртэлх бүх зардал шингэсэн) гэж тухайн барааг нэгдсэн үнэлгээнд оруулсан үеийнх нь (экспортоор гаргасан орны эдийн засгийн гаалийн хил) зах зээлийн өртгийг; ФОБ үнэ нь СИФ үнээс экспортлогч (импортлогч) орны гаалийн хил болон импортлогч (экспортлогч) орны гаалийн хилийн хооронд гарах тээврийн зардал, даатгалын хураамжийг хассантай тэнцүү байна.
- 2.4. **СИФ нөхцлийн үнэ** гэж импортын татвар болон тухайн улсын доторхи худалдаа, тээврийн нэмэгдэл ногдуулахаас өмнөх импортлогч улсын хил хүртэлх даатгал, ачаа тээврийн зардал нь ачуулсан барааны үнэд орсон, эсвэл эдийн засгийн харьяатад үзүүлсэн үйлчилгээний үнийг;
- 2.5. **ДАФ нөхцлийн үнэ** гэж экспортын барааг Монгол улсын хилийн боомт хүртэлх нөхцлийн үнээр бүртгэнэ. ДАФ нөхцлийн үнэд барааны үнэ, Монгол улсын хил хүртэлх тээвэр, даатгалын зардал орно.
- 2.6. **Боомтод нийлүүлсэн бараа** гэж гадаад орны нисэх онгоц, галт тэргэнд нийлүүлсэн шатахуун, бусад материал болон татваргүй барааны дэлгүүрийн харьяат буст борлуулсан барааг;

- 2.7. **Шилжин суугчид** гэж гадаад оронд сурах, эмчлүүлэх, аялах зорилгоор зорчсон зорчигчдоос бусад нэг жил, түүнээс дээш хугацаагаар явсан иргэдийг;
- 2.8. **Шилжин суугчдын шилжүүлэг** гэж гадаад орон руу амьдрахаар явах үедээ шилжүүлсэн гэр ахуй, хувийн хэрэглээний зүйлс, хөдлөх хөрөнгө (автомашин, тоног, төхөөрөмж гэх мэт), санхүүгийн хөрөнгийг (харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл, үнэт цаас гэх мэт) ойлгоно.
- 2.9. **Мөнгөжөөгүй алт** гэж нунтаг болон бусад хэлбэртэй боловсруулаагүй эсхүл хагас боловсруулсан алт, алтан зоос, гулдмай зэрэг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдах, үнэ цэнээ алдахгүй хадгалагдах алтыг;
- 2.10. **Гүйлгээнд ороогүй мөнгөн тэмдэгт, зоос** гэж гүйлгээнд оруулах зорилгоор Монголбанкнаас гадаад оронд хэвлүүлэн улсын хилээр оруулж байгаа үндэсний мөнгөн тэмдэгтийн /төгрөгийн/ шинэ дэвсгэрт, зоосыг;
- 2.11. **Үнэт цаас** гэж Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг /опцион/, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны зах зээлийн тухай” Монгол улсын хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг;
- 2.12. **Гүйлгээнд ороогүй үнэт цаас** гэж гүйлгээнд оруулах зорилгоор захиалагчаас гадаад оронд хэвлүүлсэн үнэт цаасыг ойлгоно.

Гурав. Төлбөрийн тэнцлийн ажил гүйлгээг бүртгэх зарчим

1. Төлбөрийн тэнцэлд эдийн засгийн харьяат ба эдийн засгийн харьяат бусын хооронд хийгдсэн гүйлгээг бүртгэхдээ орлого ба зарлагын давхар бичилтийн зарчмыг мөрдөнө. Аливаа гүйлгээ нь кредит бичилтээр орлогын талд эх үүсвэр нэмэгдүүлэхийн зэрэгцээ дебет бичилтээр зарлагын талд эх үүсвэрийг хорогдуулах бичилт хийгдэнэ.
2. Монгол Улсын төлбөрийн тэнцэлд аливаа гүйлгээг америк доллараар бүртгэж, төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг сая америк доллараар тайлагнана. Төгрөгийн гүйлгээг америк долларт хөрвүүлэхдээ Монголбанкны тухайн жил, улирлын дундаж ханшийг хэрэглэнэ.
3. Төлбөрийн тэнцэлд гүйлгээг бүртгэлийн аккруэл суурьт тулгуурлан эдийн засгийн өртөг бий болсон, хөрвүүлсэн, солилцсон, шилжүүлсэн цаг хугацаанд бүртгэнэ.

Дөрөв. Ажил гүйлгээ, актив, пассивын үлдэгдлийн үнэлгээ

- 4.1 Ажил гүйлгээг харилцагчдын тохирсон тухайн үеийн үнээр, харин актив, пассивын үлдэгдлийг тайлан тэнцэл гарах үеийн зах зээлийн үнээр үнэлэнэ.
- 4.2 Бараа солилцоо, татвар төлөлт, толгой компани болон салбар нэгжийн хооронд хийгдэх ажил гүйлгээ, менежментийн хувьд нэгдсэн үйлдвэрийн газрын хооронд хийгдэх ажил гүйлгээ, санхүүгийн лизингийн гүйлгээ,

эдийн засгийн нэгж хооронд бэлэг, тусламж хэлбэрээр шилжих ажил гүйлгээ зэргийг зах зээлийн үнээр үнэлэхгүй байж болно. Зах зээлийн үнээр тооцох боломжгүй гүйлгээний хувьд дундаж ханшийг хэрэглэнэ.

- 4.3 Төлбөрийн тэнцлийг зохиоход ашиглах зорилгоор СИФ нөхцлийн үнээрх импортын хэмжээг ФОБ /экспортлогч орны хил хүртэлх-ДАФ/ нөхцөл рүү шилжүүлэн тооцоход шаардлагатай тээвэр, даатгалын зардлыг гаалийн статистикт тусгайсан байгааг ашиглана.

Тав. Тэнцэлд ашиглагдах ангилал

Төлбөрийн тэнцлийн зохиоход “Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал” (БҮНА)(ҮСГ-ын даргын 2007 оны 01/46 тоот тушаалаар батлагдсан), “Эдийн засгийн секторын ангилал” (ҮСХ-ны 2008 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 01/57 тоот тушаалаар батлагдсан)-ыг хэрэглэнэ.

Үндэсний тооцооны системийн *санхүүгийн данс, орлогын дансны* холбогдох үзүүлэлт нь Төлбөрийн тэнцлийн стандарт үзүүлэлтэд тусгагдсан байна.

5.1 Стандарт үзүүлэлт

- 5.1.1 Монгол Улсын төлбөрийн тэнцэл, түүний стандарт үзүүлэлтийн (стандарт үзүүлэлтийг дэлгэрэнгүй байдлаар хавсралт 1-ээр харуулав) дагуу зохионо. Үүнд:

I. Урсгал данс

А. Бараа болон үйлчилгээ

- а. Бараа
- б. Үйлчилгээ

Б. Орлого

- а. Ажиллагчдын цалин хөлс
- б. Хөрөнгө оруулалтын орлого

В. Урсгал шилжүүлэг

- а. Засгийн газрын шилжүүлэг
- б. Бусад

II. Хөрөнгө ба санхүүгийн данс

А. Хөрөнгийн данс

- а. Хөрөнгийн шилжүүлэг
- б. Үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус актив хөрөнгө эзэмшил/шилжүүлэг

Б. Санхүүгийн данс

- а. Шууд хөрөнгө оруулалт
- б. Санхүүгийн хөрөнгө оруулалт
- в. Бусад хөрөнгө оруулалт

III. Цэвэр нөөцийн өөрчлөлт

- А. Нийт активын өөрчлөлт
- Б. Нийт пассивын өөрчлөлт

5.1.2 Төлбөрийн тэнцлийн хөрөнгө ба санхүүгийн дансны гүйлгээг эдийн засгийн үндсэн 4 бүлгээрбүлэглэж харуулна. Үүнд:

- Засгийн газар;
- Төв банк;
- Арилжааны банк;
- Аж ахуйн нэгж.

5.2 Алдаа, орхигдуулга

Төлбөрийн тэнцлийн бүртгэлд гүйлгээ нь нэмэх, хасах бичилтээр зөрүүгүй тэг байхаар цэвэр дүнгээр илэрхийлэгдэнэ. Бодит амьдрал дээр бүх гүйлгээг бүртгэсний дараа цэвэр дебет эсвэл цэвэр кредитэдүлдэгдэл зайлшгүй гарна. Энэ нь тэнцлийг баланслуулах явцад гарсан алдаа, зөрүү байдаг.

Төлбөрийн тэнцлийг зохиох явцад гарсан баланслалтын алдаа, зөрүүг залруулга хийн тэнцэлд тусгайлан тэмдэглэнэ. Энэхүү алдаа, зөрүүг баланслалтын буюу статистикийн зөрүү гэдэг. Энэ нь боловсруулалтын явцад бүртгэлийн үзүүлэлтийг давхар тооцсон эсвэл дутуу тооцсоноос гарна. Энэ тохиолдолд,, тооцооны алдаа, зөрүүг кредит талд тусгасан бол ижил хэмжээгээр дебет талд тусгана.

Тэнцлийн алдаа, зөрүү нь ихэвчлэн санхүүгийн дансны цэвэр зээл/цэвэр зээллэгээс хасагдах урсгал болон хөрөнгийн дансны ижил үзүүлэлт байх бөгөөд ихэнхдээ дараах хандлагатай байна. Тухайлбал:

- a. Урсгал болон хөрөнгийн дансны кредит гүйлгээний дүн хэтэрхий бага;
- b. Урсгал болон хөрөнгийн дансны дебет гүйлгээний дүн хэтэрхий их;
- c. Хөрөнгийн дансны хөрөнгийн цэвэр өсөлт хэтэрхий өндөр;
- d. Санхүүгийн дансны пассивын цэвэр өсөлтийн дүн хэтэрхий бага байна.

Тэнцлийн цэвэр алдаа, зөрүү нь хасах дүнтэй бол дээрх хандлага нь урвуугаараа байна.

Зургаа. Тайлангийн хугацаа

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг улирал, жилээр гаргана. Төлбөрийн тэнцлийг улирлаар нэгтгэхдээ харьяат ба харьяат бусын хооронд тухайн улиралд хийгдсэн гүйлгээг тайлагнана. Гүйлгээ хийгдсэн хугацааг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- | | |
|-----------------------------|--|
| Урсгал данс | – Төлбөр хийгдсэн байдлыг үл харгалзан тухайн бараа бүтээгдэхүүн нэг өмчлөлөөс нөгөө өмчлөлд шилжсэн бол |
| | – Үйлчилгээ хийгдсэн бол |
| | – Орлого, зарлагын бүртгэл хийгдсэн бол, |
| | – Ногдол ашгийн хуваарилалт хийгдсэн бол, |
| | – Шилжүүлэг хийгдсэн эсвэл авлага, өглөгийг бүртгэсэн бол, |
| Хөрөнгө ба санхүүгийн данс: | – Биет болон мөнгөн хөрөнгийн эзэмшигчийн өмчлөх эрх шилжсэн бол, |
| | – Санхүүгийн хэлцэлд оролцогч 2 тал өглөг, авлагын бичилт хийсэн бол, |
| | – Зээлийн ашиглалт, эргэн төлөлт хийгдсэн бол гүйлгээ |

хийсэн гэж үзнэ.

Төлбөрийн тэнцлийн хураангуй хүснэгтийг хавсралт 2, төлбөрийн тэнцлийг зохиоход шаардлагатай статистикийн мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын мэдээ, судалгааны жагсаалт болон мэдээлэл цуглуулах графикийг хавсралт 3, 4-аар харуулав.

Долоо. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлт, түүний бүрэлдэхүүн хэсэг

Монгол улсын төлбөрийн тэнцлийг зохиоход дараах 3 томсгосон дансыг байгуулсан байна. Үүнд:

- I. Урсгал данс
- II. Хөрөнгө ба санхүүгийн данс
- III. Нөөцийн өөрчлөлт

I. Урсгал данс

Урсгал данс нь эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондох бараа, үйлчилгээ, анхдагч орлого, орлогын дахин хуваарилалтын урсгалыг харуулах бөгөөд бараа болон үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлгийн нийлбэрээс бүрдэнэ. Урсгал дансыг (УД) дараах томъёогоор тодорхойлно:

$$\text{УД} = \text{Бараа, үйлчилгээ} + \text{Орлого} + \text{Урсгал шилжүүлэг}$$

Урсгал дансыг дараахь үзүүлэлтээр байгуулна. Урсгал дансны үзүүлэлтийг хүснэгт 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Урсгал данс, түүний үзүүлэлт

Үзүүлэлтүүд	Кредит	Дебет
I. УРСГАЛ ДАНС (А+Б+В)		
А. Бараа болон үйлчилгээ (а+б)		
а. Бараа (1+2)		
1. Экспорт Ф.О.Б.		
1.1. Зэсийн баяжмал	+	
1.2. Мөнгөжөөгүй алт	+	
1.3. Бусад	+	
2. Импорт Ф.О.Б.		
2.1. Тусламжийн бараа		-
2.2. Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж		-
2.3. Бусад		-
б. Үйлчилгээ(1:11)		
1. Тээвэр		
1.1. Зорчигч тээвэрлэлт	+	-
1.2. Ачаа тээвэрлэлт	+	-
1.3. Бусад	+	-
2. Аялал		
2.1. Албан томилолт	+	-
2.2. Хувийн		
2.2.1. Жуулчлал	+	-
2.2.2. Сургалт	+	-
2.2.3. Эмчилгээ	+	-
2.2.4. Бусад	+	-
2.3. Бусад аялал	+	-
3. Харилцаа холбооны үйлчилгээ	+	-
4. Барилгын ажил	+	-
5. Даатгалын үйлчилгээ	+	-
6. Санхүүгийн үйлчилгээ	+	-
7. Компьютер, мэдээллийн үйлчилгээ	+	-
8. Патент, тэмдэгт, лицензийн хураамж	+	-
9. Бусад бизнесийн үйлчилгээ	+	-
10. Амралт, соёлын үйлчилгээ	+	-
11. Засгийн газрын үйлчилгээ	+	-
Б. Орлого (а+б)		
а. Ажиллагчдын цалин хөлс	+	-
б. Хөрөнгө оруулалтын орлого	+	-
1. Шууд хөрөнгө оруулалт		
1.1. Хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох орлого	+	-
1.2. Зээлийн хүүний орлого	+	-
2. Санхүүгийн хөрөнгө оруулалт		
2.1. Хувьцааны орлого	+	-
2.2. Зээлийн хүүний орлого	+	-
3. Бусад хөрөнгө оруулалт	+	-
В. Урсгал шилжүүлэг (а+б)		
а. Засгийн газрын шилжүүлэг	+	-
б. Бусад урсгал шилжүүлэг		
1. Ажиллагчдын гуйвуулга	+	-
2. Бусад шилжүүлэг	+	-

Тайлбар: /+/ тэмдгээр тухайн гүйлгээний нэмэгдэх өөрчлөлт, /-/ тэмдгээр хасагдах өөрчлөлтийг тэмдэглэв.

А. Бараа болон үйлчилгээ

Урсгал дансанд дараахь бараа, үйлчилгээг тусгана.

а. Бараа. Энд эдийн засгийн харьяатын хооронд хийгдсэн барааны экспорт, импортын дүн хамаарах бөгөөд харьяат бусын барааны өмчлөх эрх шилжсэн тохиолдолд мөн бүртгэгдэнэ. Барааны экспорт, импортод дараах бараа, гүйлгээ багтана. Үүнд:

- Гадаадад цаашид боловсруулалт хийх зорилготой хил давуулж нийлүүлсэн экспортын болон ре-импортын бараа;
- Харьяат бусын усан онгоц, агаарын тээврийн хэрэгсэл дээр засварласан бараа (засварын ажил нь засвар хийхийн өмнөх эсвэл засвар хийгдсэний дараах нийт үнээр үнэлэгдэхгүй, засварын ажлын өртгөөр төлсөн эсвэл хүлээн авсан төлбөрийн дүнгээр үнэлэгдэнэ);
- Боомтод нийлүүлсэн бараа;
- Мөнгөжөөгүй алт: энд нөөц актив (мөнгөжсөн алт) - аас бусад бүх төрлийн алтны экспорт, импортын гүйлгээ;
- Гүйлгээнд ороогүй мөнгөн тэмдэгт, зоос, үнэт цаас;
- Засгийн газрын худалдааны хэлэлцээр, гадаад тусламжийн хөтөлбөр болон дайны нөхөн төлбөрийн дагуу эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж, түүнээс гаргаж байгаа иргэний болон цэргийн зориулалттай бараа /төлбөр, хандив, зээл, солилцооны бараа хамаарна/;
- Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн бараа;
- Хөрөнгө оруулалтын бараа;
- Цэргийн зориулалттай бараа;
- Арилжааны шинж чанартай зорчигчийн бараа;
- Консигнацийн бараа /улсын хил нэвтрэх үед өмчлөлийн эрх шилжээгүй, арилжих зорилго бүхий бараа, тухайлбал үзэсгэлэн, яармагт тавигдаж буй бараа/;
- Арилжааны зориулалттай програм хангамж, бичлэг хийгдсэн аудио, видео хальс;
- Толгой компани болон түүний шууд хөрөнгө оруулалтаар бий болсон охин компаний хооронд шилжүүлж буй бараа;
- Цахилгаан эрчим хүч, хий, ус;
- Улс хоорондын шуудан илгээмжийн арилжааны шинж чанартай бараа;
- Шилжин суурьшигчдын үнэ бүхий эд хогшил;
- Нэг ба түүнээс дээш жилээр түрээслэх бараа;
- Хоосон лонх, сав, баглаа, боодол;

- Тодорхой үнэ өртөг бүхий үйлдвэрлэлийн хаягдал, үлдэгдэл /тухайлбал, хаягдал лааз, хүнсний үйлдвэрлэлээс гарсан үлдэгдэл, хаягдал зэрэг/, аюултай хог хаягдал;
- Усан онгоц, агаарын болон бусад тээврийн хэрэгсэл;
- Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс болон бусад эд зүйл;
- Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын нисэх онгоцноос дотоодын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс, бусад эд зүйл болон гадаадын нисэх онгоцноос дотоодын нисэх буудалд буулгасан бараа зэрэг багтана.

1. **Экспорт ФОБ.** Харьятаас харьяат бус руу улсын хил давуулж нийлүүлсэн зэсийн баяжмал, мөнгөжөөгүй алт, боомтод нийлүүлсэн бусад бараа зэрэг бусад барааг экспортод бүртгэх бөгөөд дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Бичилт: кредит: гадаад худалдааны барааны экспортын дүн
 дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар (ГЕГ)-ын гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, татваргүй барааны борлуулалтын мэдээ болон арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан.

2. **Импорт ФОБ.** Харьят бусаас харьяатад улсын хилээр оруулж нийлүүлсэн импортын барааг бүртгэх бөгөөд дараах /тусламжийн шугамаар, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн барааны бичилт нь импортын худалдааны бичилтээс ялган тусад нь бүртгэнэ./ бичилтийг хийнэ. Үүнд:

Бичилт: дебет: гадаад худалдааны барааны импортын дүн
 кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

ГЕГ-ын гадаад худалдааны барааны статистикийн мэдээнд импортын барааг СИФ нөхцлөөр бүртгэдэг тул ФОБ нөхцөлд шилжүүлж тооцно (гадаадын бэлтгэн нийлүүлэгчдээс үзүүлсэн бараа тээвэрлэлтийн болон даатгалын үйлчилгээний үнэ, өртгийг барааны үнээс хасна).

Мэдээллийн эх үүсвэр: ГЕГ-ын гадаад худалдааны барааны статистикийн мэдээ болон арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан.

- 2.1 **Тусламжийн бараа.** Нэг улсын засгийн газрын байгууллага эсвэл олон улсын байгууллагаас хүлээн авч байгаа тусламжийн шугамаар нийлүүлэгдсэн хүмүүнлэгийн болон тусламжийн барааг энд бүртгэж, дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Бичилт дебет: гадаад худалдааны барааны импортын дүн

кредит: урсгал дансанд тусгагдах урсгал
шилжүүлгийн Засгийн газрын
шилжүүлгийн дүн

Мэдээллийн эх үүсвэр: ГЕГ-ын гадаад худалдааны барааны статистик мэдээ болон Сангийн яам (СЯ)-ны техник туслалцааны ашиглалтын мэдээ, Засгийн газарт олон улсын байгууллагаас шилжүүлсэн шилжүүлгийн мэдээ.

2.2 Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь олон улсын хөрөнгө оруулалтын нэг төрөл бөгөөд харьяат бусаас харьяатын үйлдвэрийн газарт нийлүүлсэн тоног төхөөрөмжийг энд бүртгэж, дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Бичилт кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт,
гадаадаас орсон, хувь нийлүүлсэн
хөрөнгө

дебет: гадаад худалдааны барааны импортын
дүн

Мэдээллийн эх үүсвэр: ГЕГ-ын гадаад худалдааны барааны статистик мэдээ болон Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын мэдээ, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн мэдээ.

Экспорт, импортын гүйцэтгэлд оруулан тооцохгүй бараа:

- Гадаад оронд суугаа элчин сайдын яам, консулын газар, худалдааны төлөөлөгчийн газар болон Монгол Улсын эзэмшлийн газар нутагт байрлаж буй бусад байгууллагын Монгол Улсаас худалдаж авсан бараа;
- Монгол Улсын эдийн засгийн нутаг дэвсгэрт эдийн засгийн харьяатаас эдийн засгийн харьяат бус-д шилжүүлсэн санхүүгийн бус хөрөнгө;
- Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл;
- Барааг худалдах орны нутагт байрших дипломат болон төлөөлөгчийн газраар дамжуулан Засгийн газрын хэрэгцээнд худалдаж авсан бараа;
- Эдийн засгийн харьяат бусын тайлант хугацаанд Монгол Улсаас худалдаж авсан, худалдсан бараа /барааг худалдаж авсан, худалдсан үнийн зөрүү нь төлбөрийн тэнцэл болон үндэсний тооцоонд ашиглагдана/;
- мөнгөжсөн алт;
- гүйлгээнд оруулсан мөнгөн дэвсгэрт, зоос, үнэт цаас /үүнд гадаад валютын зузаатгал орно/;
- хилийн чанадад 1 жилээс дээшгүй хугацаагаар гаргасан, гаалийн нутаг дэвсгэрт 1 жилээс дээшгүй хугацаагаар оруулсан бараа;—улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа;
- захиалгын сонин, тогтмол хэвлэл;
- захиалгын дагуу хийгдсэн програм хангамж, түүнийг агуулж байгаа диск, эх бичлэг хийгдсэн аудио болон видео хальс; захиалгаар хийгдсэн зураг төсөл;
- нэг жилээс дээшгүй хугацаагаар түрээслэх бараа;
- устгах бараа;

- дахин ашиглагдах эргэлтийн хоосон лонх, сав, баглаа, боодол;

Барааны экспорт, импортын дүнд оруулж тооцохгүй, тусгайлан бүртгэх бараа:

- гадаад орны нутаг дэвсгэрт газардсан Монголын нисэх онгоцны хэрэгцээнд олгосон түлш, шатахуун, хүнс болон бусад эд зүйл;
- гадаад орны нутаг дэвсгэрт байгаа Монголын нисэх онгоцноос гадаадын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс болон бусад эд зүйл;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын Монгол Улсаас худалдаж авсан бараа;
- давагдашгүй хүчин зүйлийн улмаас гарсан хохирлыг арилгах, барилга байгууламж барих зэрэг тодорхой зорилгоор гаалийн нутаг дэвсгэрт 1 жилээс дээшгүй хугацаагаар нэвтрүүлсэн машин механизмыг дотоодын хэрэглээнд оруулах эсхүл хилийн чанадад гаргах тохиолдолд;
- засварын зориулалттай бараа;
- улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бараа.

б. Үйлчилгээ. Энэ нь тээвэр, аялал жуулчлал, харилцаа холбоо, барилгын ажил, даатгал, санхүү, компьютер мэдээлэл, патент, барааны тэмдэгтийн хураамж, лиценз, бусад бизнес, амралт соёлын болон Засгийн газрын үзүүлсэн үйлчилгээний нийлбэрээс бүрдэнэ. Харьяатаас харьяат бус-д үзүүлсэн үйлчилгээний орлогыг кредит бичилтээр эх үүсвэрийг нэмэгдүүлж, харин харьяатын харьяат бус-д төлсөн үйлчилгээний зардлыг дебет бичилтээр эх үүсвэрийг хорогдуулж бүртгэнэ.

1. Тээвэр. Тээврийн үйлчилгээнд бүх төрлийн (агаарын, төмөр замын, авто замын, усан болон хоолойн тээвэр) тээврийн хэрэгслээр үзүүлсэн ачаа тээвэр болон зорчигч тээвэрлэлт, ачаа, тээш тээвэрлэлттэй холбоотой үйлчилгээ, бусад туслах үйлчилгээ (боомтын үйлчилгээ, навигацийн үйлчилгээ, дамжин өнгөрсний үйлчилгээ зэрэг), тээврийн хэрэгслийг жолоочтой нь хамт түрээслэх үйлчилгээг бүртгэнэ. Тээврийн даатгалын үйлчилгээ, харьяат бусын боомтод нийлүүлсэн бараа, тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн засвар энд хамаарахгүй.

1.1. Зорчигч тээвэрлэлт. Энд харьяат, харьяат бусын хооронд хийгдсэн гүйлгээ, тухайлбал, харьяатын тээвэрлэсэн харьяат бусын олон улсын зорчигч тээвэрлэлт (кредит), харьяат бусын тээвэрлэсэн харьяатын олон улсын зорчигч тээвэрлэлт (дебет)-ийн бүх үйлчилгээг бүртгэнэ. Харьяат бусын эдийн засгийн нутаг дэвсгэр дээр тээвэрлэсэн зорчигч тээврийн үйлчилгээ мөн энд хамаарна. Харин аялалтай холбоотой зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ энд хамаарахгүй. Зорчигч тээвэрлэлттэй холбоотой дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Зорчигч тээвэрлэлтийн орлого

Бичилт: кредит: зорчигч тээврийн орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Зорчигч тээвэрлэлтийн зардал

Бичилт: кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

дебет: зорчигч тээврийн зардал

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, онгоц, галт тэрэг, авто замын тийз борлуулалтын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

- 1.2. **Ачаа тээвэрлэлт.** Энд харьяат, харьяат бусын хооронд хийсэн харьяатын тээвэрлэсэн харьяат бусын олон улсын ачаа тээвэрлэлт (кредит), харьяат бусын тээвэрлэсэн харьяатын олон улсын ачаа тээвэрлэлт (дебет)-ийн бүх үйлчилгээ багтана. Ачаа тээврийн үйлчилгээнд ачаа тээшийг ачаалах, буулгах болон тээвэрлэлтийн бусад үйлчилгээ мөн багтана.

Бүх төрлийн тээврийн үйлчилгээний дебет бичилт (төлбөр) нь харьяат бусын Монгол Улсад импортоор оруулж буй барааны тээврийн үйлчилгээг харуулах бөгөөд экспортлогч орноос Монгол Улсад импортлохоор тухайн улсын хилийн боомтод шилжсэн үед бүртгэгдэнэ. Тээврийн үйлчилгээний кредит бичилт (хүлээн авсан) нь харьяатын Монгол Улсаас нийлүүлж байгаа экспортын барааны тээврийн үйлчилгээ бөгөөд хилийн боомтод шилжсэн үед бүртгэгдэнэ. Бусад улс орнууд хооронд хийсэн харьяатын экспортын барааны тээврийн үйлчилгээ мөн энд багтана. Импортын ачаа тээвэрлэлтийн СИФ нөхцлийн үнийг ФОБ нөхцлийн үнэд шилжүүлэн тооцсон тээврийн зардлыг энд бүртгэж, дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Ачаа тээврийн орлого

Бичилт: кредит: ачаа тээврийн орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: МИАТ, Улаанбаатар төмөр замын болон бусад тээврийн байгууллагын ачаа тээвэрлэлтийн мэдээ, арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн тусгайлсан судалгаа.

Ачаа тээврийн зардал

Бичилт: дебет: ачаа тээврийн зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: МИАТ, Улаанбаатар төмөр замын болон бусад тээврийн байгууллагын ачаа тээвэрлэлтийн мэдээ, арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

- 1.3. **Тээвэрлэлттэй холбоотой бусад үйлчилгээ.** Харьяатын эзэмшлийн ачаа тээврийн хэрэгсэл болон худалдааны

зориулалттай бусад тээврийн хэрэгслийг харьяат бус зорчигч болон ачаа тээврийн зориулалттайгаар жолоочтой нь тодорхой хугацаанд түрээслэх үйл ажиллагаа энд багтана.

Тээвэрлэлттэй холбоотой бусад туслах үйл ажиллагаа, тухайлбал, усан онгоцны зогсоол, нисэх буудал, зогсоолын үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ, карго эрхлэх, ачаа тээш хадгалах, баглах, чирэх болон жолоодлогын үйлчилгээ, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээ, ачаа тээшийг осол, гамшгаас аврах, баримт бичиг бүрдүүлэх зэрэг үйлчилгээ энд багтана. Үйлчилгээний орлого, зардлыг дараах бичилтээр тэнцэлд тусгана. Үүнд:

Тээвэрлэлттэй холбоотой бусад үйлчилгээний орлого

Бичилт: кредит: тээвэрлэлттэй холбоотой бусад үйлчилгээний орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: МИАТ, Улаанбаатар төмөр замын болон бусад тээврийн байгууллагын боомтын үйлчилгээний болон дамжин өнгөрсний орлогын мэдээ, Иргэний нисэхийн ерөнхий газрын навигацийн орлогын мэдээ.

Тээвэрлэлттэй холбоотой бусад үйлчилгээний зардал

Бичилт: дебет: тээвэрлэлттэй холбоотой бусад үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: МИАТ, Улаанбаатар төмөр замын болон бусад тээврийн байгууллагын боомтын үйлчилгээний болон дамжин өнгөрсний төлбөрийн мэдээ.

- 2. Аялал жуулчлалтай холбогдон гарах гүйлгээ¹.** Монгол улсад 1 жилээс доош хугацаагаар аялах зорилготой аялагчдын худалдан авсан эсвэл үзүүлсэн бараа, үйлчилгээний орлого, зардлыг энд хамруулна. Олон улсын зорчигч тээврийн үйлчилгээ энд хамаарахгүй. Түүнчлэн батлан хамгаалах зорилготой цэргийн баазад ажиллах албан хаагч, дипломат корпус, элчин сайдын яам зэрэг байгууллагын ажилтан болон түүнийг дагалдах төлөөлөгч, тухайн улсын харьяатын эрхлэн явуулах бизнесийн үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ энд мөн хамаарахгүй.

Гадаад улсад авч гарсан аялалтай холбогдох зардал (нисэх буудлын хураамж, визийн хураамж гэх мэт), хувийн болон албан хэрэгцээний зориулалтаар худалдан авсан бараа (бэлэг дурсгалын зүйлс, ариун цэврийн бараа, хоол хүнсний зүйлс гэх мэт) болон үйлчилгээний зардал (зочид буудал, хоол хүнс, үзвэр үйлчилгээ гэх мэт) энд тусгагдана. Аяллыг зорилгоор нь албан томилолт, хувийн ба бусад аялал гэсэн 3 бүлэгт ангилж бүртгэнэ.

¹ ҮТС болон Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын боловсруулсан гарын авлагад хэрэглэгддэг аялал жуулчлал гэсэн ухагдахуунтай ижил болно.

Хэрэв Монгол улсын харьяат нэг жил эсвэл түүнээс дээш хугацаагаар гадаад оронд сурч, эмчлүүлж байгаа бол нэг жил хүртэлх хугацаа гэсэн дүрэм үйлчлэхгүй. Суралцагч, эмчлүүлэгчийн сургалт болон эмчилгээтэй холбоотой зардал (сургалтын төлбөр, эмчилгээний зардал, ор, байрны хөлс, эмчийн хөлс зэрэг)-ын талаарх мэдээллийг нэмэлт мэдээлэл болгож цуглуулна. Хувийн, соёлын болон амралтын зорилгоор хийгдсэн багш, эмч нарын гадаадад хийсэн үйлчилгээг энд бүртгэнэ.

2.1 Албан томилолт. Засгийн газрын болон олон улсын байгууллага, бизнес эрхлэгч байгууллагын ажилтан олон улсын хурал, зөвлөгөөн, уулзалт, туршлага судлах зэргээр гадаад оронд албан томилолтоор ажиллахтай холбоотой үйл ажиллагааг энд багтааж, орлого, зардлын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Албан томилолтын орлого

Бичилт: кредит: аяллын албан томилолтын зардал

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Олон улсын байгууллага, гадаад орнуудын Засгийн газар болон бусад харьяат бусын зардлаар Монгол Улсад зохион байгуулагдсан хурал, уулзалт, зөвлөгөөний зардлын судалгаа, Монгол Улсад томилолтоор ажилласан олон улсын ба гадаадын байгууллагын ажиллагсдын томилолтын талаарх асуулга судалгаа, Буянт-Ухаа дахь Чингис хаан нисэх буудлын удирдах газрын олон улсын нисэх буудлын хураамжийн мэдээ, Гадаад харилцааны яам, Сангийн яам, Гадаад оронд суугаа Монгол улсын Элчин сайдын яам, консулын газар, олон улсын байгууллагын визийн хураамжийн орлогын мэдээ нь мэдээллийн эх үүсвэр болно.

Албан томилолтын зардал

Бичилт: дебет: аяллын албан томилолтын зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн (Цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" бүлэгт бусад гүйлгээний хамт шууд тавигдах тул төсвийн байгууллагын зардлын кредит бичилтийг хийхгүй)

Мэдээллийн эх үүсвэр: СЯ-ны Монгол Улсын төрийн болон бусад байгууллагын ажиллагсдын гадаад оронд хурал, зөвлөгөөнд оролцсон болон ажилласан томилолтын зардлын судалгаа, Монгол Улсад суугаа гадаадын элчин сайдын яам, консулын газарт Монгол Улсын иргэдийн төлсөн гадаад орнуудын визийн хураамжийн судалгаа.

2.2 Хувийн аялал. Албан томилолтоос бусад харьяат, харьяат бусын хийсэн амралт зугаалгын үйл ажиллагаа, тухайлбал, гадаад оронд аялах, урлаг, спорт, уралдаан, тэмцээнд оролцох, найз нөхөд, ах дүү, хамаатан садныдаа зочлох, мөргөл хийх, шашны зан үйлийн ажиллагаанд оролцох болон

сургалт, эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр болон бусад үйлчилгээний зардал энд багтана. Мөн аялагчдын дамжин өнгөрөх үйл ажиллагаа энд хамаарна.

2.2.1 **Жуулчлал.** Гадаад оронд аялах, жуулчлах, урлаг, спорт, уралдаан, тэмцээнд оролцох, найз нөхөд, хамаатан садныдаа зочлох болон мөргөл хийх, шашны зан үйлийн ажиллагаанд оролцох зэрэг амралт зугаалгын үйл ажиллагаа орно. Дараахь бичилтийг хийнэ.

Жуулчлалын орлого

Бичилт: кредит: жуулчлалын орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Аялал жуулчлалын газрын гадаадын жуулчдын тоо, жуулчны орлогын мэдээ, Хил хамгаалах ерөнхий газрын Монгол Улсын хилээр орсон/гарсан гадаадын иргэдийн мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа, Монгол Улсад ирж буй гадаадын жуулчдын судалгаа, Буянт-Ухаа дахь Чингис хаан нисэх буудлын удирдах газрын олон улсын нисэх буудлын хураамжийн мэдээ, Гадаад орнууд дахь Монгол улсын Элчин сайдын яам, консулын газар, олон улсын байгууллагын визийн хураамжийн орлогын мэдээ.

Жуулчлалын зардал

Бичилт: дебет: жуулчлалын зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Монгол Улсын хилээр орсон/гарсан монгол иргэдийн мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа, Гадаадад жуулчлагч монгол иргэдийн судалгаа, Монгол иргэдийн төлсөн гадаад орнуудын визийн хураамжийн судалгаа.

2.2.2 **Сургалт.** Харьяатын гадаад оронд суралцах төлбөр, харьяат бусын Монгол улсад суралцахтай холбогдон гарсан гүйлгээ энд багтана. Монгол Улсын Сургалтын төрийн сангийн зардлын бичилт энд хамаарахгүй. Сургалтын орлого, зардлын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Сургалтын орлого

Бичилт: кредит: гадаадын оюутнуудын сургалтын төлбөр

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба

харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны их, дээд сургуулиудад суралцаж буй гадаадын оюутнуудын тоо, сургалтын төлбөрийн судалгаа. **Сургалтын зардал**

Бичилт: дебет: гадаадад суралцагчдын сургалтын төлбөр

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Сургалтын төрийн сангийн мэдээ, гадаад орнуудад Сургалтын төрийн сангаас бусад хөрөнгөөр суралцагч монгол оюутнуудын судалгаа.

2.2.3 **Эмчилгээ.** Монгол улсын иргэдийн гадаад оронд эмчлүүлсний эмчилгээний төлбөр, харьяат бусын Монгол Улсад ирж эмчлүүлсэн эмчилгээний төлбөрийг энд хамруулж, дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Эмчилгээний орлого

Бичилт: кредит: гадаадын иргэдийн эмчилгээний төлбөр

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Эрүүл мэндийн яамны гадаадын иргэдийн эмчилгээний төлбөрийн судалгаа.

Эмчилгээний зардал

Бичилт: дебет: Монгол иргэдийн гадаадад эмчлүүлсэн эмчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаадад эмчлүүлэгч Монгол улсын иргэдийн эмчилгээний зардлын талаарх тусгайлсан судалгаа.

2.2.4 **Бусад.** Харьяат бус аялагчдын дамжин өнгөрөх үйл ажиллагаа энд хамаарна.

Бусад орлого

Бичилт: кредит: хувийн аяллын бусад орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Аялал жуулчлалын газрын гадаадын жуулчдын тоо, жуулчны орлогын мэдээ, Хил

хамгаалах ерөнхий газрын Монгол Улсын хилээр орсон/гарсан гадаадын иргэдийн мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа, Монгол Улсад ирж буй гадаадын жуулчдын судалгаа, Буянт-Ухаа дахь Чингис хаан нисэх буудлын удирдах газрын олон улсын нисэх буудлын хураамжийн мэдээ.

Бусад зардал

Бичилт: дебет: хувийн аяллын бусад зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Монгол Улсын хилээр орсон/гарсан монгол иргэдийн мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа, Гадаадад жуулчлагч монгол иргэдийн судалгаа, Монгол иргэдийн төлсөн гадаад орнуудын визийн хураамжийн судалгаа.

- 2.3 **Бусад аялал.** Монгол улсын иргэдийн төлсөн гадаад орнуудын визийн хураамжийн үйл ажиллагааг энд хамруулж, дараах бичилтийг хийнэ.

Бусад аяллын орлого

Бичилт: кредит: аяллын бусад орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Хил хамгаалах ерөнхий газрын Монгол Улсын хилээр орсон/гарсан гадаадын иргэдийн мэдээ, Буянт-Ухаа дахь Чингис хаан нисэх буудлын удирдах газрын олон улсын нисэх буудлын хураамжийн мэдээ.

Бусад аяллын зардал

Бичилт: дебет: аяллын бусад зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад орнууд дахь Монгол Улсын Элчин сайдын яам, консулын газар, олон улсын байгууллагад Монгол иргэдийн төлсөн гадаад орнуудын визийн хураамжийн судалгаа.

3. **Харилцаа холбооны үйлчилгээ.** Энд харьяат болон харьяат бусын хооронд харилцаа холбооны хэрэгслээр дамжин хийгдэж байгаа дараах үйлчилгээг хамруулан авч үзнэ. Энэ үйлчилгээнд авиа, зураг дамжуулах шуудан холбооны үйлчилгээ, энгийн болон буухиа шуудангийн бүх төрлийн үйлчилгээ (захидал, хэвлэл, илгээмж гэх мэт), телефон, телекс, телеграф, радио, телевизийн өргөн нэвтрүүлэг, сансрын холбоо, электрон шуудан, факсын үйлчилгээ зэрэг телекоммуникацийн үйлчилгээ, бүх төрлийн мэдээллийн сүлжээ (Ройтерс, СВИФТ гэх мэт), хиймэл дагуулын

ашиглалт (кабелийн телевизийн суваг гэх мэт) зэрэг үйлчилгээ багтах бөгөөд дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Харилцаа холбооны үйлчилгээний орлого

Бичилт: кредит: харилцаа холбооны үйлчилгээний орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа мэдээллийн эх үүсвэр болно.

Харилцаа холбооны үйлчилгээний зардал

Бичилт: дебет: харилцаа холбооны үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа болон Монгол банк, арилжааны банкуудын СВИФТ болон Ройтерсийн үйлчилгээний зардлын мэдээ.

4. **Барилгын ажил.** Аж ахуйн нэгж, байгууллагын эдийн засгийн нутаг дэвсгэрээс гадна богино хугацаанд (нэг жил хүртэлх) хийж гүйцэтгэсэн барилгын ажил үйлчилгээний болон суурилуулах ажлын орлого, зардлыг энд хамруулна. Гадаад орны аж ахуйн нэгжийн салбар нэгж (шууд хөрөнгө оруулалттай) энд бүртгэгдэхгүй. Түүнчлэн Монгол Улсад татвар төлөгч гадаадын барилгын компани, салбар аж ахуйн нэгж мөн хамаарахгүй. Харин гүйцэтгэгч компанийн төслийн зориулалтаар импортолж оруулсан барааг үйлчилгээний хөлсөнд хамруулж тооцох бөгөөд орлого, зардлын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Барилгын ажил, үйлчилгээний орлого

Бичилт: кредит: барилгын ажил, үйлчилгээний орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Барилгын ажил үйлчилгээний зардал

Бичилт: дебет: барилгын ажил, үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

5. **Даатгалын үйлчилгээ.** Энд харьяат, харьяат бусын хооронд хийсэн шууд, давхар даатгалын бүх төрлийн үйлчилгээний орлого, зардал хамраарна. Энэ төрлийн даатгалын үйлчилгээ нь ачаа тээврийн даатгал (экспорт, импорт хийгдэж байгаа барааны даатгал)-ын үйлчилгээ, шууд даатгалын бусад төрөл (тухайлбал, амь даатгал – жилийн тогтмол даатгал, бусад осол гэмтлийн, эрүүл

мэндийн, хариуцлагын, галын, нисэхийн зэрэг даатгал)-ийн даатгал болон давхар даатгалыг багтаана. Даатгалын гүйлгээтэй холбоотой агентийн хураамжийн төлбөрийг энд мөн бүртгэнэ.

Экспорт, импортын барааны ачаа тээврийн даатгалын үйлчилгээг ФОБ нөхцлийн үнээр үнэлнэ. Үүнтэй уялдан даатгалын үйлчилгээний зардлын тооцоонд импортын СИФ нөхцлийн үнийг ФОБ нөхцлийн үнэд шилжүүлэн тооцож тусгах бөгөөд дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Даатгалын үйлчилгээний орлого

Бичилт: кредит: даатгалын үйлчилгээний орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, СЯ-ны даатгалын үйлчилгээний орлогын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ.

Даатгалын үйлчилгээний зардал

Бичилт: дебет: даатгалын үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

6. **Санхүүгийн үйлчилгээ.** Харьяат, харьяат бусын хооронд хийгдсэн даатгал, тэтгэврийн сангаас бусад төрлийн санхүүгийн зуучлал (аккредитивын шимтгэл, санхүүгийн лизингийн шимтгэл, валют хөрвүүлсний шимтгэл гэх мэт), туслах чанарын ажил, үйлчилгээний (санхүүгийн брокерийн хөлс, активын удирдлагын үйлчилгээний хөлс, диллерүүдийн хөлс гэх мэт) орлого, зардлыг бүртгэнэ. Энд өрийн бичиг, зуучлалын үйлчилгээний хөлсийг оруулж тооцно.

Санхүүгийн үйлчилгээний орлого

Бичилт: кредит: санхүүгийн үйлчилгээний орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ.

Санхүүгийн үйлчилгээний зардал

Бичилт: дебет: санхүүгийн үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ.

7. **Компьютер, мэдээллийн үйлчилгээ.** Харьяат, харьяат бусын хооронд үзүүлсэн цахим тооцоолох техникийн талаар зөвлөгөө өгөх/авах, программ хангамж, мэдээллийн үйлчилгээ (мэдээлэл

солилцох, мэдээллийн сан бий болгох, хадгалах, он-лайн динамик үзүүлэлтийг бий болгох, мэдээлэл боловсруулалт, компьютерийн техник хангамжийн зөвлөгөө өгөх, мэдээллийн дизайн болон бүтэц, зохион байгуулалт, хэрэглээний программ хангамжийг суурилуулах, компьютерын сүлжээ, мэдээллийн суваг бэлтгэх), компьютер, түүнтэй холбоотой тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, мэдээллийн агентлагийн үйлчилгээ, сонин, тогтмол хэвлэлийн захиалга зэрэг үйлчилгээг энд хамруулна.

Компьютер, мэдээллийн үйлчилгээний орлого

Бичилт: кредит: компьютер, мэдээллийн үйлчилгээний орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Компьютер, мэдээллийн үйлчилгээний зардал

Бичилт: дебет: компьютер, мэдээллийн үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ.

8. **Патент, тэмдэгт, лицензийн хураамжийн үйлчилгээ.** Харьяат, харьяат бусын хооронд хийгдсэн үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус, биет бус хөрөнгө болох худалдааны тэмдэгт, зохиогчийн эрх, патент, технологийг ашиглах, франчайзийн эрхийн хураамж ба үйлдвэрлэгчийн давуу эрх, бүтээлийн бүрэн эхийг ашиглах эрхийн хураамжууд энд хамаарах бөгөөд дараах бичилт хийгдэнэ. Үүнд:

Патент, тэмдэгт, лицензийн хураамжийн үйлчилгээний орлого

Бичилт: кредит: патент, тэмдэгт, лицензийн хураамжийн үйлчилгээний орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Оюуны өмчийн газрын оюуны өмчийн хураамж болон эрх худалдсан орлогын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

Патент, тэмдэгт, лицензийн хураамжийн үйлчилгээний зардал

Бичилт: дебет: патент, тэмдэгт, лицензийн хураамжийн үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа, гадаадын брэнд нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн судалгаа, оюуны өмчийн газрын оюуны өмчийн хураамж болон эрх худалдсан орлогын мэдээ.

9. **Бизнесийн бусад үйлчилгээ.** Энд харьяат, харьяат бусын хооронд барааг зуучлах үйлчилгээ, тээврийн хэрэгслийн түрээс, зөвлөхийн үйлчилгээ, бараа, ажил үйлчилгээний сурталчилгаа,

эрдэм шинжилгээ, судалгааны ажил, соёл урлаг, биеийн тамирын чиглэлийн үйлчилгээний орлого, зардал хамаарна.

- a. Барааг зуучлах үйлчилгээ. Энд барааг худалдаалах болон худалдааны үйл ажиллагаатай холбоотой бусад үйлчилгээ багтана. Барааг зуучлах үйлчилгээ нь бараа, үйлчилгээний гүйлгээний хураамжаас бүрдэнэ. Худалдаачин, худалдааны брокер, наймаачин, комиссын агент зэргээр хийгддэг харьяат болон харьяат бусын хоорондын худалдааны гүйлгээ байна. Түүнчлэн, агаарын тээврийн хэрэгсэл зэрэг дээр хийгдэх худалдаа болон дуудлагат худалдаа багтана. Барааг худалдаалах үйлчилгээ нь харьяат бусаас бараа худалдан авах үйлчилгээ байх ба энэ худалдан авсан бараагаа өөр харьяат буст худалдаалах үйлчилгээ орно. Барааг худалдан авах үеийн, худалдах үеийн үнийн зөрүү нь худалдааны үйлчилгээний үнэ буюу худалдааны нэмэгдэл болно. Хэрэв худалдаан авсан бараа, бүтээгдэхүүнээ тайлангийн хугацаанд дахин борлуулж худалдаагүй бол тайлангийн эхэнд барааны импортоор бүртгэж, хасах импортоор тайлангийн эцэст бүртгэнэ. Худалдаа нь цэвэр дүнгээр бүртгэгдэх ба шинжилгээ, судалгааны зорилгоор нийт дүнг тусад нь бүртгэнэ.
- b. Харьяат, харьяат бусын хооронд хийгдэх тээврийн хэрэгслийг жолоочгүйгээр нь (санхүүгийн лизингээс бусад) түрээслэх үйл ажиллагааг бүртгэнэ.
- c. Төрөл бүрийн бизнесийн, мэргэжлийн, техникийн болон бусад үйлчилгээнд дараах үйлчилгээг, тухайлбал хуулийн, бүртгэлийн, удирдлагын зөвлөгөө болон үйлчилгээ (харьяат, харьяат бусын хооронд хийгдсэн хуулийн зөвлөгөө, төлөөлөх, баримтжуулах, бүртгэлийн, аудитын, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэл хөтлөх, татварын зөвлөгөө багтана), бизнесийн зөвлөгөө, зааварчилгаа өгөх эсвэл үйл ажиллагааны бусад туслалцаа үзүүлэх зэрэг үйлчилгээг хамааруулна. Харьяат, харьяат бусын хооронд хийгдсэн зар сурталчилгаа, зах зээлийн судалгааны үйлчилгээнд загвар зохиох, бүтээл тууривах, сурталчилгааны байгууллагаар хийлгэсэн зах зээлийн зар сурталчилгааны ажил, төхөөрөмж суурилуулах болон сурталчилгаа хийх талбайг худалдах, худалдан авах, худалдааны яармагийн үзэсгэлэнгийн үйлчилгээ, гадагш гаргасан бүртээгдэхүүнд урамшуулал үзүүлэх, зах зээлийн судалгаа болон олон нийтийн санал бодлыг судалж, бүртгэх үйл ажиллагаа орно. Эдгээрийг нарийвчлан авч үзвэл:
 - Харьяат, харьяат бусын хооронд хийгдсэн шинэ бүтээгдэхүүнийг бий болгох үйл ажиллагаатай холбоотой судалгаа, шинжилгээ, хөгжлийн асуудлаарх үзүүлсэн үйлчилгээ орно. Энд байгалийн шинжлэх ухааны болон нийгэм, хүмүүнлэгийн салбарт хийгдэх үйл ажиллагаа байх ба технологийн дэвшлийг таниулах ажил багтана.
 - Архитектур, инженер болон техникийн бусад үйлчилгээнд харьяат, харьяат бусын хооронд хийгдэх хотын болон бусад хөгжлийн төслийн архитектур дизайн, далан, гүүр, нисэх буудал, хорих газрын төсөл зэргийн төлөвлөлт,

төслийн дизайныг зохицуулах үйл ажиллгааг судлах, зураг зүйг зохиох, бүтээгдэхүүнийг турших, шалгах, үнэмлэх олгох болон техникийн оношлогооны үйл ажиллагаа орно.

- Хөдөө аж ахуй, уул уурхай болон түүний талбай бэлтгэх үйлчилгээнд газар тариалангийн үйлчилгээ (шавьж устгал, ариутгал хийж хамгаалах үйлчилгээ, тариан талбайг нэмэгдүүлэх); ойн аж ахуйн үйлчилгээ, уул уурхайтай холбоотой үйлчилгээ (тухайлбал, хүдрийн шинжилгээ гэх мэт)-г (гэхдээ реэкспорт орохгүй) багтана.
- Харьяат болон харьяат бусын хооронд хийгдэх бусад үйлчилгээнд ажилтан байршуулах, хамгаалал болон мөрдлөгийн үйлчилгээ, түүнчлэн орчуулга, фото зургийн үйлчилгээ, барилга, байшин, байгууламжийн цэвэрлэгээ зэрэг багтана. Харьяат бусын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үзүүлж байгаа орон нутгийн үйлчилгээ, орон сууцны хангамж, үйлчилгээ зэрэг нь барилгын үйлчилгээний төлбөрт орж тооцогдоно. Бизнесийн бусад үйлчилгээний орлого, зардлын дараах бичилт хийгдэнэ. Үүнд:

Бизнесийн бусад үйлчилгээний орлого

Бичилт: кредит: бизнесийн бусад үйлчилгээний орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны гадаадад зохиосон урлаг, спортын тоглолтын орлогын мэдээ, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын монгол улсад зохиогдсон олон улсын үзэсгэлэн, яармагийн орлогын мэдээ, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын арбитрагийн шүүхийн орлогын мэдээ.

Бизнесийн бусад үйлчилгээний зардал

Бичилт: дебет: бизнесийн бусад үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа, СЯ-ны гадаадын зөвлөхийн үйлчилгээний төлбөрийн мэдээ, Монгол Улсад ирж тоглосон гадаадын дуучид, хамтлагт төлсөн төлбөрийн судалгаа, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын гадаадад зохиогдсон олон улсын үзэсгэлэн, яармагын зардлын мэдээ, Боловсрол, соёл, шинжлэх ухааны гадаадын уралдаан, тэмцээний тасалбарын Монгол Улсад борлогдсон борлуулалтын мэдээ.

10. **Амралт, соёлын үйлчилгээ.** Харьяат, харьяат бусын хооронд хийгдсэн дуу бичлэг, кино жүжгийн зураг авалт, киног нийтэд гаргах эрхийн хураамж, музей, номын сантай холбоотой соёлын үйлчилгээний хураамжийг багтаана. Соёлын үйлчилгээг дараахь 2 бүлэгт ангилна. Үүнд:

- 1) дуу, дүрс харах, түүнтэй холбоотой үйлчилгээ, тухайлбал, кино зураг (кино болон видео хуурцаг)-ийн үйлдвэрлэл, радио, телевизийн хөтөлбөрийн төлбөрийн үйлчилгээ хамаарах бөгөөд харьяат жүжигчин, удирдаач, продюсерийн (харьяат бусын эдийн засгийн нутаг дэвсгэрт хийсэн) гадаад оронд явуулсан үйлдвэрлэл, үйлчилгээний хураамж, түрээсийн төлбөр эсвэл хүлээн авсан нэхэмжлэл, тусгай бүсэд үзүүлэх бүтээлийг нийтэд гаргах эрх зэргийг мөн багтаан авч үзнэ. Түүнчлэн театр, хөгжмийн бүтээл, спортын арга хэмжээ, цирк зэрэгт оролцож байгаа жүжигчин, продюсер зэргийн хураамж болон телевиз, радиогийн бүтээлийг нийтэд түгээх эрхийн төлбөр, хураамж мөн багтана.
- 2) соёл, амралтын бусад үйлчилгээ хамаарах бөгөөд музей, номын сан, архивын болон амралт, спорт, зугаалгын бусад үйлчилгээ энд багтана. Түүнчлэн гадаад оронд зохиогдсон багш, эмч нарын эчнээ сургалтын төлбөр мөн багтана.

Орлогын дебет бичилтэнд цэвэр нөөцийн “нийт актив, бусад актив” гэсэн бүлэгт төсвийн байгууллагын орлогын бэлэн мөнгө, харилцахын дүн тусгагдах бөгөөд төсвийн байгууллагын орлогын дебет бичилтийг энд хийхгүй. Бусад үйлчилгээний орлого, зардлын хүрээнд дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Амралт, соёлын үйлчилгээний орлого

Бичилт: кредит: амралт, соёлын үйлчилгээний орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Гадаадын кино студийн Монгол улсад төлсөн зураг авалтын хураамжийн мэдээ.

Амралт, соёлын үйлчилгээний зардал

Бичилт: дебет: амралт, соёлын үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Монголын дуучид, хамтлагийн гадаадын бичлэгийн студид төлсөн төлбөрийн судалгаа.

11. **Засгийн газрын үйлчилгээ.** Засгийн газрын үйлчилгээнд олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар, цэргийн бааз, батлан хамгаалахын агентлаг, гадаад орнуудын элчин сайдын яам, консулын газрын харьяат бустай хийсэн үйлчилгээний зардал багтана. Гадаад орнуудад суугаа Монгол улсын элчин сайдын яамд, консулын газар болон элчин сайдын яам, консулын газрын төлөөлөл, шуудан солилцоо зэрэг Монгол Улсын харьяаттай хийсэн үйлчилгээ энд хамаарахгүй. Засгийн газрын үйлчилгээнд дипломат бараа, үйлчилгээ (бичиг хэргийн зардал, тавилга, уур, ус, цахилгаан дулааны хангамжийн зардал, албаны унаа, тэдгээрийн үйлчилгээ, засвар болон албаны дайллага) болон дипломатууд, консулын ажилтны хувийн зардал нь тэдгээрийн байрлаж буй нутаг дэвсгэрийн эдийн засгийн хүрээнд хамаарна. Цэргийн

зориулалттай бус тусламжийн үйлчилгээ нь ямар нэгэн төлбөр хураамж төлдөггүй тул энд зөвхөн шилжүүлэг хийгдэнэ. Эцэст нь, НҮБ-ын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа, энх тайвныг сахиулах хүчин зэрэгт үзүүлж буй хангамж үйлчилгээ нь засгийн газрын үйлчилгээнд багтана. Засгийн газрын үйлчилгээний орлого, зардлын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Засгийн газрын үйлчилгээний орлого

Бичилт: кредит: засгийн газрын үйлчилгээний орлого

дебет: цэвэр нөөц, нийт актив, бусад

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад харилцааны яам, СЯ-ны Гадаадын элчин сайдын яам, консулын газар, олон улсын байгууллагуудын суурин төлөөлөгчийн газрын Монгол Улсад төлж буй зардлын мэдээ.

Засгийн газрын үйлчилгээний зардал

Бичилт: дебет: засгийн газрын үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад харилцааны яамны Гадаад орнууд дахь Монгол Улсын элчин сайдын яам, консулын газрын тухайн оршин сууж буй улсад төлсөн зардлын мэдээ.

Б. Орлого

Энд харьяат, харьяат бусын хооронд хийгдэх дараах 2 төрлийн ажил гүйлгээ багтана. Үүнд:

- 1) харьяат бус ажиллагчдад (хилийн/боомтын, улирлын чанартай болон бусад богино хугацааны) төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого;
- 2) гадаад санхүүгийн активын гадаад хөрөнгө оруулалтын орлого

а. Ажиллагчдын цалин хөлс. Монгол Улсад байгаа гадаадын элчин сайдын яам, консулын газар, олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газарт ажилладаг монгол ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлогыг энд бүртгэнэ. Ажиллагчдын нэрийн өмнөөс нийгмийн даатгалын санд төлөгдөгдөг даатгалын төлбөр, Монгол Улсын эдийн засгийн сонирхлын төвд ажилладаг хил/боомтын, улирлын эсвэл богино хугацааны (1 жилээс бага хугацаагаар) ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлогыг мөн энд оруулж бүртгэх бөгөөд дараах бичилт хийгдэнэ. Үүнд:

Ажиллагчдын цалин хөлсний орлого

Бичилт: кредит: ажиллагчдын цалин хөлс

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад харилцааны яам, СЯ-ны Монгол улсад байгаа гадаадын элчин сайдын яам, консулын газар, олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар дахь монгол ажиллагчдын цалин түүнтэй адилтгах орлогын судалгаа.

Ажиллагчдын цалин хөлсний зардал

Бичилт: дебет: ажиллагчдын цалин хөлс

кредит: цэвэр нөөц, нийт актив, бусад актив (бусад гүйлгээний хамт шууд тавигдах тул кредит бичилтийг хийхгүй.)

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад харилцааны яам, СЯ-ны Гадаад орнууд дахь Монгол улсын элчин сайдын яам, консулын газар дахь орон нутгийн ажиллагсдын цалин түүнтэй адилтгах орлогын мэдээ.

- б. Хөрөнгө оруулалтын орлого.** Энд харьяат ба харьяат бусын хооронд харилцан шилжүүлсэн ногдол ашиг, хүүгийн орлогыг бүртгэнэ. Энэ төрлийн гүйлгээг шууд хөрөнгө оруулалтын, санхүүгийн хөрөнгө оруулалтын болон бусад хөрөнгө оруулалтын орлого гэсэн 3 үндсэн бүлэгт хувааж бүртгэнэ.

Хуваарилсан ногдол ашиг (дивиденд) нь төлбөр ногдуулсан өдрөөр, хүүний орлого нь аккруэль сууриар бүртгэгдэнэ. Хэрэв хүүний орлого төлөгдөөгүй бол орлогын бичилт нь мөн төлөгдөөгүй байдлаар санхүүгийн дансанд бичилт хийгдэнэ.

- 1. Шууд хөрөнгө оруулалтын орлого.** эдийн засгийн сонирхлын үүднээс нэг улсын харьяат аж ахуйн нэгж (хөрөнгө оруулагч) нь нөгөө улсын харьяат аж ахуйн нэгжид (хөрөнгө оруулалтыг хүлээн авагч) урт хугацаатайгаар нийлүүлсэн хөрөнгөнөөс орох орлогыг энд багтаана. Шууд хөрөнгө оруулалтын орлого нь хувь нийлүүлсэн хөрөнгөнд ногдох орлого, зээлийн хүүний орлого гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Шууд хөрөнгө оруулалтын орлогыг гадаадад хийсэн шууд хөрөнгө оруулалтын цэвэр дүнгээр бичигдэнэ (хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт болон зээлийн хүүний орлогын дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт болон зээлийн хүүний орлогын төлбөрийн дүнг хасаж тооцсоноор).

- 1.1. Хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох орлого.** Энд шууд хөрөнгө оруулалтад хуваарилсан ногдол ашиг (дивиденд), түүнээс хөрөнгө оруулалтанд буцааж оруулсан орлогыг бүртгэнэ. Бүртгэлийг цэвэр дүнгээр өөрөөр хэлбэл, харьяат бусаас шилжиж ирсэн орлогын дүнгээс харьяат бус-д төлсөн дүнг хасч цэвэр дүнг кредит, дебет талын аль нэг дээр бүртгэнэ. Хэрвээ цэвэр дүн нэмэх тэмдэгтэй буюу гадаадаас орсон орлого илүү бол кредит талд бүртгэж орлогын бичилт хийнэ, цэвэр дүн хасах тэмдэгтэй буюу гадаадад шилжүүлсэн орлого илүү бол дебет талд бүртгэж зарлагын бичилт хийнэ.

- 1.1.1** Шууд хөрөнгө оруулалтад хуваарилсан ногдол ашгийн орлого, зарлагын бичилтийг дараах байдлаар хийнэ.
Үүнд:

Ногдол ашгийн орлого:

Бичилт: кредит: Шууд хөрөнгө оруулалтад хуваарилсан ногдол ашгийн орлого
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Ногдол ашгийн зардал:

Бичилт: дебет: Шууд хөрөнгө оруулалтад хуваарилсан ногдол ашгийн орлого
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа нь орлого зарлагын бичилт.

1.1.2 Хөрөнгө оруулалтанд буцааж оруулсан орлого болох орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого, зарлагын бичилтийг дараах байдлаар хийнэ. Үүнд:

Орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого:

Бичилт: кредит: Орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого
дебет: Санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадад гарсан шууд хөрөнгө оруулалт

Орлогын дахин хөрөнгө оруулалтын зардал:

Бичилт: дебет: **Орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого**
кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон шууд хөрөнгө оруулалт

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа нь зээлийн хүүгийн орлого, зарлагын бичилт

1.2. **Зээлийн хүүний орлого.** Байгууллага хоорондын зээлийн хүүгийн орлого болон төлбөрийг энд бүртгэнэ. Бичилтийг цэвэр дүнгээр өөрөөр хэлбэл, харьяат бусаас шилжиж ирсэн хүүгийн орлогын дүнгээс харьяат бусад шилжүүлсэн хүүгийн төлбөрийг хасч цэвэр дүнг кредит, дебет талын аль нэг дээр бүртгэнэ. Хэрвээ цэвэр дүн нэмэх тэмдэгтэй буюу гаднаас олсон хүүгийн орлого илүү бол кредит талд бүртгэж орлогын бичилт хийнэ. Харин цэвэр дүн хасах тэмдэгтэй буюу гадаадад төлсөн хүүгийн төлбөр илүү бол дебет талд бүртгэж зарлагын бичилт хийнэ. Зээлийн хүүгийн орлого, зарлагын бичилтийг дараах байдлаар хийнэ. Үүнд:

Зээлийн хүүний орлого

Бичилт: кредит: зээлийн хүүний орлого
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Зээлийн хүүний зарлага

Бичилт: дебет: зээлийн хүүний орлого
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

2. Санхүүгийн хөрөнгө оруулалтын орлого. Санхүүгийн хөрөнгө оруулалтын орлогод хувьцаа, бонд, үнэт цаас, өрийн бичиг, мөнгөний захын хэрэгслэлийн хүү болон санхүүгийн деривативын гүйлгээнээс олсон хүүний орлогыг энд бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө оруулалтын орлого нь хөрөнгийн хувьцааны орлого (дивиденд), зээлийн хүүний (бонд, үнэт цаас, өрийн бичиг болон бусад, мөнгөний хэрэгслэлийн хүү, санхүүгийн деривативын гүйлгээний орлого гэх мэт) орлого гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

2.1. Хөрөнгийн хувьцааны орлого. Энд хоёрдогч зах зээлээр дамжуулж худалдан авсан хувьцаанд хуваарилсан ногдол ашиг (дивиденд), түүнээс хувьцаанд буцааж оруулсан орлогыг бүртгэнэ. Харьяат бус-д шилжүүлсэн зарлагын гүйлгээг дебет бичилтээр, харьяат бусаас хүлээж авсан орлогын гүйлгээг кредит бичилтээр бүртгэнэ.

Хөрөнгийн хувьцааны орлого

Бичилт: кредит: хувьцааны орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Хөрөнгийн хувьцааны зарлага

Бичилт: дебет: хувьцааны орлого

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

2.2. Зээлийн хүүний орлого. Зээлийн хүүний орлогод бонд, үнэт цаас, өрийн бичиг, мөнгөний захын хэрэгслэлийн хүү, санхүүгийн деривативын гүйлгээнээс олсон хүүний орлогыг бүртгэнэ. Харьяатаас харьяат бусад шилжүүлсэн зарлагын гүйлгээг дебет бичилтээр, харьяат бусаас хүлээж авсан орлогын гүйлгээг кредит бичилтээр бүртгэнэ. Зээлийн хүүний орлогын дебет бичилтийг хийхдээ Монголбанкны орлогын дебет бичилтийг хийхгүй. Энэ нь цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" гэсэн бүлэгт бусад гүйлгээний хамт шууд тусгагдана. Түүнчлэн цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" гэсэн бүлэгт бусад гүйлгээний хамт шууд бичилт хийгдэх тул Засгийн газар, Монголбанкны хүүгийн зардлын кредит бичилтийг мөн хийхгүй. Зээлийн хүүний орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Зээлийн хүүний орлого

Бичилт: кредит: зээлийн хүүний орлого

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт

Зээлийн хүүний зарлага

Бичилт: дебет: зээлийн хүүний орлого
 кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа, Монголбанкны гадаадын үнэт цаас, өрийн бичиг, бондын хүүний төлбөр болон санхүүгийн хэрэгслэлийн гүйлгээгээр олсон хүүгийн зардлын мэдээ.

- 3. Бусад хөрөнгө оруулалтын орлого.** Энд Засгийн газар, Монголбанк, арилжааны банк, аж ахуйн нэгж, иргэдийн харьяат бус-д олгосон/авсан урт, дунд, богино хугацаатай, хөнгөлөлттэй болон арилжааны зээлийн хүүгийн орлого/төлбөрийг бүртгэнэ. Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламжийн хүүний орлого, харьяат бусын харилцах, хадгаламжид төлсөн хүүний төлбөр энд багтана. Энэ ангилалд мөн амьдралын (амь насны) даатгалын нөөц болон тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох өрхийн хийсвэр орлого мөн хамаарна.

Бусад хөрөнгө оруулалтын орлого нь цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" гэсэн бүлэгт шууд бичилт хийгдэх бөгөөд бусад хөрөнгө оруулалтын орлогын кредит бичилтэнд Монголбанкны орлогын дебет бичилт ба Засгийн газар, Монголбанкны хүүгийн зардлын кредит бичилтийг хийхгүй. Бусад хөрөнгө оруулалтын орлого, зарлагын дараах бичилт хийгдэнэ. Үүнд:

Бусад хөрөнгө оруулалтын орлого

Бичилт: кредит: бусад хөрөнгө оруулалтын орлого
 дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив,
 бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа, Монгол банкны гадаадад байршуулсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлогын мэдээ.

Бусад хөрөнгө оруулалтын зарлага

Бичилт: дебет: бусад хөрөнгө оруулалтын орлого
 кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив,
 бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа, Засгийн газрын гадаад зээлийн хүүгийн төлбөрийн мэдээ, Монголбанкинд бүртгэсэн валютын зээлийн мэдээ.

В. Урсгал шилжүүлэг

Урсгал шилжүүлэгт бодит нөөц болон санхүүгийн хэрэгслийг солилцож буй гүйлгээнээс бусад төрлийн гүйлгээг багтааж ойлгоно. Урсгал шилжүүлэг нь татвар төлсний дараах орлогод шууд нөлөөлж, бараа, үйлчилгээний хэрэглээнд өөрчлөлт оруулна. Урсгал шилжүүлэг нь хандив (донор)-ын боломжит орлого, хэрэглээг бууруулж, харин хүлээн авагчийн орлого, хэрэглээг нэмэгдүүлэх бөгөөд биет ба мөнгөн хэлбэрээр илэрхийлэгдэнэ.

Мөнгөн шилжүүлгийг ямар нэгэн үндсэн хөрөнгө худалдан авах зориулалтаар хийсэн бол түүнийг хөрөнгийн шилжүүлэгт бүртгэнэ. Урсгал шилжүүлгийг Засгийн газрын шилжүүлэг болон бусад гэсэн 2 үндсэн бүлэгт ангилж бүртгэнэ.

а. **Засгийн газрын шилжүүлэг.** Засгийн газрын өөр улсын Засгийн газар болон олон улсын байгууллагатай хийсэн дараахь төрлийн гүйлгээг энд бүртгэнэ. Үүнд:

- төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэх зориулалтаар олгосон мөнгөн тусламж,
- байгалийн болон бусад гамшгийг даван туулах зориулалтаар олгосон бүх төрлийн барааны хандив, эмнэлгийн хэрэгслэлийн тусламж,
- зэр зэвсэг, холбогдох тоног төхөөрөмж зэрэг зарим нэг цэргийн тоног төхөөрөмжийн хандив,
- олон улсын байгууллагын гишүүнчлэлийн татвар, олон улсын байгууллагаас гишүүний асуудлаар засгийн газарт шилжүүлсэн шилжүүлэг,
- олон улсын байгууллага, гадаадын Засгийн газрын техник туслалцааны хүрээнд ажиллагсдын цалин, бусад холбогдох зардлын санхүүжилт;

Орлогын татвар болон нийгмийн даатгалын төлбөр зэрэг бусад шилжүүлэг нь Засгийн газрын шилжүүлгийн кредит талд тусгагдана. Нийгмийн халамж, татварын буцаан олголт, нөхөн төлбөр, тэтгэвэр олголт нь дебет талд бичигдэнэ. Засгийн газрын орлогын дебет бичилт нь цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" гэсэн бүлэгт шууд тусгагдаж, харин Засгийн газрын орлогын дебет бичилтийг энд хийхгүй. Засгийн газрын шилжүүлгийн орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Засгийн газрын шилжүүлгийн орлого

Бичилт: кредит: Засгийн газрын шилжүүлэг

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: ГЕГ-ын Гаалийн статистикийн мэдээ, СЯ-ны техник туслалцааны ашиглалтын мэдээ, Монголбанк, СЯ-ны Засгийн газарт олон улсын байгууллагаас шилжүүлсэн шилжүүлгийн мэдээ.

Засгийн газрын шилжүүлгийн зарлага

Бичилт: дебет: Засгийн газрын шилжүүлэг

кредит: цэвэр нөөц, нийт актив, бусад актив, бусад гүйлгээний дүнтэй хамт бичигдэнэ.

Мэдээллийн эх үүсвэр: Монголбанк, СЯ-ны Олон улсын байгууллагад төлсөн гишүүнчлэлийн төлбөрийн мэдээ.

б. **Бусад урсгал шилжүүлэг.** Бусад шилжүүлгийг ажилчдын гуйвуулга, бусад шилжүүлэг гэсэн хоёр бүлэгт ангилж бүртгэнэ.

1. **Ажиллагчдын гуйвуулга.** Гуйвуулга гэдэгт мөнгөн болон биет хэлбэрийн гуйвуулгыг ойлгож, кредит талд гадаад орнуудад 1 ба

түүнээс дээш жилээр ажиллаж буй Монгол иргэдээс Монгол Улс руу илгээсэн гуйвуулгыг, дебет талд Монгол Улсад 1 ба түүнээс дээш хугацаагаар ажиллаж буй гадаадын иргэдийн гадаад орнууд руу шилжүүлсэн гуйвуулгыг бүртгэнэ. Ажиллагчдын гуйвуулгын орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Ажиллагчдын гуйвуулгын орлого

Бичилт: кредит: ажилчдын гуйвуулга

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Шуудангийн үйл ажил ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн Илгээмжийн мэдээ, Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Банк бус санхүүгийн байгууллагын гадаад гүйлгээний тайлан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтэд зуучлагч компаниудын гадаадад гэрээгээр ажиллаж буй монгол иргэдийн мэдээ, гадаадад ажиллаж буй Монгол иргэдийн судалгаа.

Ажиллагчдын гуйвуулгын зарлага

Бичилт: дебет: ажилчдын гуйвуулга

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын гадаад ажиллагчдын цалингийн мэдээ, Шуудангийн үйл ажил ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн илгээмжийн мэдээ.

2. Бусад шилжүүлэг. Бусад шилжүүлэгт дараах гүйлгээг хамруулж, бүртгэнэ.

Бусад шилжүүлгийн орлого хэсэгт дараах гүйлгээг хамруулна. Үүнд:

- ан агнах, загас барих эрхийн хураамжийн төлбөр,
- олон улсын улаан загалмайн байгууллага, гадаад орнуудын шашны болон сайн дурын болон урлаг соёлын байгууллагын шугамаар байгалийн болон бусад гамшгийг даван туулах зориулалтаар олгосон бүх төрлийн барааны хандив, эмнэлгийн хэрэгслэлийн тусламж, мөнгөн хандив,
- гадаад орнуудад зохиогдсон спорт, урлагийн болон бусад тэмцээн, уралдааны шагнал, сугалааны хонжворын шагнал, бусад шагнал зэрэг болно.

Бусад шилжүүлгийн зарлага хэсэгт дараах гүйлгээг хамруулна. Үүнд:

- олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагуудад шилжүүлсэн гишүүнчлэл, хандивын шилжүүлэг,
- гадаад орнуудад болох спорт, урлагийн болон бусад тэмцээн, уралдааны тасалбарын Монгол Улсад борлуулсан орлого зэрэг болно.

Бусад шилжүүлэг нь цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" гэсэн бүлэгт шууд тусгагдах тул Байгаль орчны яамны орлогын кредит бичилт энд хийгдэхгүй. Бусад шийлжүүлгийн орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Бусад шилжүүлгийн орлого

Бичилт: кредит: бусад шилжүүлэг

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Байгаль, орчны яамны Гадаадын анчдын төлсөн хураамжийн мэдээ, Боловсрол, шинжлэх ухааны яамны Гадаадын уралдаан, тэмцээнд Монгол иргэдийн авсан шагналын мэдээ, олон улсын улаан загалмайн байгууллага, гадаадын төрийн бус байгууллагын шугамаар ирсэн хандив, тусламжийн судалгаа.

Бусад шилжүүлгийн зарлага

Бичилт: дебет: бусад шилжүүлэг

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Олон улсын улаан загалмайн байгууллага ба гадаадын төрийн бус олон нийтийн байгууллагад шилжүүлсэн гишүүнчлэл, хандивын төлбөрийн судалгаа.

II. Хөрөнгө ба санхүүгийн данс

Хөрөнгө ба санхүүгийн данс нь хөрөнгийн данс (хөрөнгийн эзэмшлийн өөрчлөлт) ба санхүүгийн данс (мөнгөн хөрөнгийн өөрчлөлт) гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Хөрөнгө ба санхүүгийн данс нь (ХСД) дараах томъёогоор тодорхойлогдоно:

$$\text{ХСД} = \text{Хөрөнгийн данс} + \text{Санхүүгийн данс}$$

Хөрөнгө ба санхүүгийн дансны үзүүлэлтийг хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Хөрөнгө ба санхүүгийн данс

Үзүүлэлтүүд	Кредит	Дебет
II. ХӨРӨНГӨ БА САНХҮҮГИЙН ДАНС (А+В)		
А. Хөрөнгийн данс (а+б)		
а. Хөрөнгийн шилжүүлэг		
1. Засгийн газар		
1.1. Хүчингүй болгосон өр	+	-
1.2. Газар	+	-
1.3. Бусад	+	-
2. Бусад сектор		
2.1. Шилжин суугчдын шилжүүлэг	+	-
2.1.1. Гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгө	+	-
2.1.2. Санхүүгийн хөрөнгө	+	-
2.2. Хүчингүй болгосон өр	+	-
2.3. Бусад	+	-
б. Үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус актив хөрөнгө эзэмшил/шилжүүлэг		
Б. Санхүүгийн данс(а+б+в)		
а. Шууд хөрөнгө оруулалт		
1. Гадаадад гарсан		
1.1. Хувь нийлүүлсэн хөрөнгө		-
1.2. Орлогын дахин хөрөнгө оруулалт		-
1.3. Бусад хөрөнгө		-
2. Гадаадаас орсон		
2.1. Хувь нийлүүлсэн хөрөнгө	+	
2.2. Орлогын дахин хөрөнгө оруулалт	+	
2.3. Бусад хөрөнгө	+	
б. Санхүүгийн хөрөнгө оруулалт		
1. Актив		
1.1. Хөрөнгийн хувьцаа		
1.1.1. Төв банк	-	+
1.1.2. Засгийн газар	-	+
1.1.3. Арилжааны банк	-	+
1.1.4. Аж ахуйн нэгж	-	+
1.2. Өрийн бичиг		
1.2.1. Төв банк	-	+
1.2.2. Засгийн газар	-	+
1.2.3. Арилжааны банк	-	+
1.2.4. Аж ахуйн нэгж	-	+
2. Пассив		
2.1. Хөрөнгийн хувьцаа		
2.1.1. Төв банк	+	-
2.1.2. Засгийн газар	+	-
2.1.3. Арилжааны банк	+	-
2.1.4. Аж ахуйн нэгж	+	-
2.2. Өрийн бичиг		
2.2.1. Төв банк	+	-
2.2.2. Засгийн газар	+	-
2.2.3. Арилжааны банк	+	-
2.2.4. Аж ахуйн нэгж	+	-
в. Бусад хөрөнгө оруулалт		
1. Актив		

Үзүүлэлтүүд	Кредит	Дебет
1.1. Худалдааны зээл	-	+
1.2. Зээл		
1.2.1. Төв банк		
1.2.1.1. Урт хугацааны	-	+
1.2.1.2. Богино хугацааны	-	+
1.2.2. Засгийн газар		
1.2.2.1. Урт хугацааны	-	+
1.2.2.2. Богино хугацааны	-	+
1.2.3. Арилжааны банк		
1.2.3.1. Урт хугацааны	-	+
1.2.3.2. Богино хугацааны	-	+
1.2.4. Аж ахуйн нэгж		
1.2.4.1. Урт хугацааны	-	+
1.2.4.2. Богино хугацааны	-	+
1.3. Бэлэн мөнгө ба харилцах		
1.4. Бусад актив		
2. Пассив		
2.1. Худалдааны зээл	+	-
2.2. Зээл		
2.2.1. Төв банк		
2.2.1.1. Урт хугацааны	+	-
2.2.1.2. Богино хугацааны	+	-
2.2.2. Засгийн газар		
2.2.2.1. Урт хугацааны	+	-
2.2.2.2. Богино хугацааны	+	-
2.2.3. Арилжааны банк		
2.2.3.1. Урт хугацааны	+	-
2.2.3.2. Богино хугацааны	+	-
2.2.4. Аж ахуйн нэгж		
2.2.4.1. Урт хугацааны	+	-
2.2.4.2. Богино хугацааны	+	-
2.3. Бэлэн мөнгө ба харилцах	+	-
2.4. Бусад пассив	+	-

Тайлбар: /+/ тэмдгээр тухайн гүйлгээний нэмэгдэх өөрчлөлт, /-/ тэмдгээр хасагдах өөрчлөлтийг тус тус тэмдэглэв.

А. Хөрөнгийн данс

Хөрөнгийн дансны гүйлгээг хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

а. Хөрөнгийн шилжүүлэг. Үндсэн хөрөнгийн өмчлөгч эзэн өөрчлөгдсөн, зээлийг хүчингүй болгосноор өглөг зээлдэгчийн мэдэлд шилжсэн болон үндсэн хөрөнгө худалдан авахаар шилжүүлсэн бэлэн мөнгө, элчин сайдын яам, олон улсын байгууллагын эзэмшилд шилжүүлсэн газрын шилжүүлгийн гүйлгээ энд багтана. Хөрөнгийн шилжүүлгийн ангилал нь ҮТС-ийн хүрээнд бүрэн нийцсэн байна.

Хөрөнгийн шилжүүлэг нь биет болон мөнгөн хэлбэрээр хийгдэж болно.

Биет хэлбэрийн хөрөнгийн шилжүүлэгт 1) үндсэн хөрөнгийн өмчлөлийг шилжүүлэх; 2) зээлдүүлэгч болон зээлдэгчийн 2 талын гэрээгээр зээлдүүлэгч тал нь зээлдэгчийнхээ өрийг хүчингүй болгох зэрэг шилжүүлгүүд багтана.

Хөрөнгийн шилжүүлгийг Засгийн газар болон бусад гэсэн ангиллаар бүртгэж, бусад секторт Төв банк, арилжааны банк, аж ахуйн нэгжийг нэгтгэж харуулна. Засгийн газар болон бусад секторт хүчингүй болгосон өрийг аль алинд нь тусгаж, харин шилжин суугчдын хөрөнгийн шилжүүлгийг бусад секторт тусгана.

1. Засгийн газар. Засгийн газрын хөрөнгийн шилжүүлэг нь Засгийн газрын хүчингүй болгосон өр, газрын хөрөнгийн шилжүүлгээс бүрдэнэ.

Хэрэв Монгол Улсын Засгийн газар зээлдүүлэгч бол харьяат бус зээлдэгчид гэрээний дагуу хөрөнгийг шилжүүлэх буюу харьяат бус зээлдүүлэгчээс Монгол Улсын Засгийн газарт гэрээний дагуу хөрөнгийг шилжүүлсэн тохиолдолд хөрөнгийн шилжүүлгийн бүртгэлийг хийнэ.

1.1. Хүчингүй болгосон өр. Хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр зээлийн өрийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хүчингүй болгосон тохиолдолд зээлдэгч орлогын гүйлгээ хийж, харин зээлдүүлэгчийн тал зарлагын гүйлгээний дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Хүчингүй болгосон өрийн орлого

Бичилт: кредит: хүчингүй болгосон өр

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, пассив, зээл, засгийн газар

Мэдээллийн эх үүсвэр: Засгийн газрын хүчингүй болгосон өрийн мэдээ.

Хүчингүй болгосон өрийн зарлага

Бичилт: дебет: хүчингүй болгосон өр

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, пассив, зээл, засгийн газар

Мэдээллийн эх үүсвэр: Сангийн яамны Засгийн газрын хүчингүй болгосон өрийн мэдээ.

1.2. Газар. Монгол Улсад суугаа гадаадын элчин сайдын яам, олон улсын байгууллагын эзэмшилд шилжсэн газрын төлбөрийг орлого талд, харин гадаад орнуудад суугаа Монголын элчин сайдын яамны худалдан авсан газрын төлбөрийг зарлага талд бүртгэнэ. Газрын орлогын дебет болон газрын зарлагын кредит гүйлгээний бичилтийг энд хийхгүй. Газрын орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Газрын орлого:

Бичилт: кредит: Газар

дебет: цэвэр нөөц, нийт актив, бусад актив

Газрын зарлага:

Бичилт: дебет: Газар

кредит: цэвэр нөөц, нийт актив, бусад актив

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад харилцааны яам, СЯ-ны газрын мэдээ.

1.3. **Бусад.** Засгийн газрын хөрөнгийн шилжүүлгэнд хөрөнгө оруулалтын тусламжийн шилжүүлэг голлон хийгдэнэ. Хөрөнгийн хуримтлалыг бий болгодог барилгын төсөл байх бөгөөд хөрөнгө оруулалтын төсөл урт хугацаанд үргэлжилбэл, энэ хэмжээгээр бэлэн төлөгдсөн төлбөр хийгдэж болно. Энэ гүйлгээг хөрөнгийн шилжүүлгээр мөн бүртгэнэ. Засгийн газрын хөрөнгийн биет шилжүүлэг нь тээврийн хэрэгсэл, машин, тоног төхөөрөмж болон барилга, байгууламжийг харьяат бус-д шилжүүлсэн хөрөнгийн шилжүүлэг байна. Бусад хөрөнгийн шилжүүлгийн орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Бусад хөрөнгийн шилжүүлгийн орлого

Бичилт: кредит: Засгийн газрын бусад шилжүүлэг
дебет: цэвэр нөөц, нийт актив, бусад актив

Бусад хөрөнгийн шилжүүлгийн зарлага

Бичилт: дебет: Засгийн газрын бусад шилжүүлэг
кредит: цэвэр нөөц, нийт актив, бусад актив

Мэдээллийн эх үүсвэр: Засгийн газрын хөрөнгийн шилжүүлгийн мэдээ.

2. **Бусад сектор.** Засгийн газраас бусад секторт хамаарах харьяат, харьяат бусын хооронд хийгдэх хөрөнгийн шилжүүлэг болон шилжин суугчдын шилжүүлэг, хүчингүй болгосон өр болон бусад хөрөнгийн шилжүүлгийг энд багтана.

2.1. **Шилжин суугчдын шилжүүлэг.** Гадаад орнуудад шилжин суугчдийн шилжүүлгийг төлбөрийн тэнцэлд зарлагын гүйлгээгээр дебет талд бүртгэж, манай оронд шилжин суугчдынхыг орлогод бүртгэж, кредит бичилт хийнэ.

2.1.1. **Гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгө.** Гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгө болон экспортын барааны хувьд гаалийн статистикийн мэдээнд тусгагдах тул дебет бичилтийг хийхгүй. Гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгийн орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Шилжин суугчдын гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгийн шилжүүлгийн орлого

Бичилт: кредит: шилжин суугчдын гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгийн шилжүүлэг
дебет: импортын барааны бусад гүйлгээ

Мэдээллийн эх үүсвэр: ГЕГ-ын гадаад худалдааны барааны мэдээ.

Шилжин суугчдын гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгийн шилжүүлгийн зарлага

Бичилт: дебет: шилжин суугчдын гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх

хөрөнгийн шилжүүлэг

кредит: экспортын барааны бусад гүйлгээ

Мэдээллийн эх үүсвэр: Засгийн газрын хөрөнгийн шилжүүлгийн мэдээ.

2.1.2. **Санхүүгийн хөрөнгө.** Энд шилжин суугчдын санхүүгийн хөрөнгийн шилжүүлгийн орлого, зарлагыг бүртгэж, дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Шилжин суугчдын санхүүгийн хөрөнгийн шилжүүлгийн орлого

Бичилт: кредит: хөрөнгийн данс, хөрөнгийн шилжүүлэг, бусад салбар, шилжин суугчдын шилжүүлэг

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Шилжин суугчдын санхүүгийн хөрөнгийн шилжүүлгийн зарлага

Бичилт: кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

дебет: хөрөнгийн данс, хөрөнгийн шилжүүлэг, бусад салбар, шилжин суугчдын шилжүүлэг

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан.

2.2. **Хүчингүй болгосон өр.** 1.1-т тусгасан Засгийн газрын хүчингүй болгосон өрийн гүйлгээтэй ижил зарчмаар бичилт хийнэ.

Хүчингүй болгосон өрийн орлого

Бичилт: кредит: хүчингүй болгосон өр

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, пассив, зээл, бусад салбар

Хүчингүй болгосон өрийн зарлага

Бичилт: дебет: хүчингүй болгосон өр

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, пассив, зээл, бусад салбар

Мэдээллийн эх үүсвэр: СЯ-ны хүчингүй болгосон өрийн судалгаа.

б. **Үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус актив хөрөнгө.** Энд үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус актив хөрөнгө, худалдааны тэмдэгт, зохиогчийн эрх, патент, технологийг худалдан авсан, худалдсантай холбоотой шилжүүлгийн гүйлгээг бүртгэж, дараах бичилт хийнэ. Үүнд:

Үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус актив хөрөнгийн шилжүүлгийн орлого

Бичилт: кредит: хөрөнгийн данс, үйлдвэрлэдэггүй санхүүгийн бус

актив хөрөнгө

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Оюуны өмчийн газрын Оюуны өмчийн эрх худалдсан орлогын мэдээ.

Үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус актив хөрөнгийн шилжүүлгийн зарлага

Бичилт: кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

дебет: хөрөнгийн данс, үйлдвэрлэдэггүй санхүүгийн бус хөрөнгө

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан.

Б. Санхүүгийн данс

Санхүүгийн дансны бүлэгт тухайн эдийн засгийн гадаад актив, пассивын гүйлгээг бүртгэдэг бүх данс хамаарна.

Гадаад актив нь мөнгөжсөн алт, зээлжих тусгай эрхийн харилцах данс, харьяат бусаас авах авлагын дансдаас бүрдэнэ. Гадаад пассив нь харьяат бусд төлөх өглөгийг харуулна. Энэ бүлгийн гүйлгээг шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө оруулалт гэсэн 3 ангиллаар бүртгэнэ. Санхүүгийн данс нь бодит нөөцийг (тухайлбал, бүтээгдэхүүн, үйлчилгээ гэх мэт) солилцож буй гүйлгээний үед урсгал данстай, үйлдвэрлэдэггүй санхүүгийн бус активийг (патент, барааны тэмдэгт, технологи гэх мэт) солилцож буй гүйлгээний үед хөрөнгийн данстай, санхүүгийн бүтээгдэхүүнийг хооронд нь солилцож буй гүйлгээний үед өөр бусад санхүүгийн данстайгаа тус тус харьцана.

а. Шууд хөрөнгө оруулалт. Шууд хөрөнгө оруулалт гэж харьяат бус нь нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид нийлүүлэх, салбар ба харьяа нэгжээ байгуулах үйл ажиллагааг хэлнэ. Энд анхны хөрөнгө оруулалтаас хойш хөрөнгө оруулагчаас нэмж нийлүүлсэн хөрөнгийг мөн хамруулна. Төлбөрийн тэнцэлд шууд хөрөнгө оруулалтын хэмжээг аж ахуйн нэгжийн бүртгэлээр бус, бодит гүйцэтгэлээр бүртгэнэ. Монгол Улсад оруулсан гадаадын хөрөнгө оруулалтыг орлогын бичилтээр, гадаадад нийлүүлсэн хөрөнгө оруулалтыг зарлагын бичилтээр харуулна.

1. Гадаадад гарсан шууд хөрөнгө оруулалт.

1.1. Хувь нийлүүлсэн хөрөнгө. Энд гадаадад гаргасан хөрөнгө оруулагчийн анхны нийлүүлсэн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгөд хуваарилагдсан ногдол ашгийг буцааж оруулсан хөрөнгө, гаднаас нэмж оруулсан хөрөнгийг тус тус бүртгэнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь бараа материал, тоног төхөөрөмж, эд зүйлс зэрэг биет болон мөнгөн хэлбэрээр байна.

1.1.1. Бараа материал, тоног төхөөрөмж, эд зүйлсийн орлого:

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадад гарсан, хувь нийлүүлсэн хөрөнгө

кредит: урсгал данс, бараа ба үйлчилгээ, бараа, экспорт, бусад

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, ГЕГ-ын Гаалийн гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, Гадаадын худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, Аж ахуйн нэгжийн судалгаа.

1.1.2. Бэлэн мөнгө.

Бэлэн мөнгөний орлого

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадад гарсан, хувь нийлүүлсэн хөрөнгө

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, ГЕГ-ын Гаалийн гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, Гадаадын худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

Бэлэн мөнгөний зарлага

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон, хувь нийлүүлсэн хөрөнгө

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

1.2. Орлогын дахин хөрөнгө оруулалт.

Хөрөнгө оруулалтанд буцааж оруулсан орлогын бичилтийг дараах байдлаар хийнэ.

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон шууд хөрөнгө оруулалт, орлогын дахин хөрөнгө оруулалт

кредит: урсгал данс, орлого, орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн

судалгаа, санхүүгийн тайлан нь зээлийн хүүгийн орлого, зарлагын бичилт.

- 1.3. Бусад хөрөнгө.** 100 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай компани, түүний салбар, харъяа нэгжээ байгуулах зорилгоор гадаадад нийлүүлсэн хөрөнгийг бүртгэнэ.

Бусад хөрөнгийн орлого

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон, бусад хөрөнгө

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Бусад хөрөнгийн зарлага

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадагшаа гарсан, бусад хөрөнгө

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, ГЕГ-ын Гаалийн гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, Гадаадын худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

2. Гадаадаас орсон шууд хөрөнгө оруулалт

- 2.1. Хувь нийлүүлсэн хөрөнгө.** Энд хөрөнгө оруулагчийн анхны нийлүүлсэн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгөд хуваарилагдсан ногдол ашгийг буцааж оруулсан хөрөнгө, гаднаас нэмж оруулсан хөрөнгийг энд бүртгэнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь бараа материал, тоног төхөөрөмж, эд зүйлс зэрэг биет болон мөнгөн хэлбэрээр байна.

2.1.1. Бараа материал, тоног төхөөрөмж, эд зүйлсийн орлого

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон, хувь нийлүүлсэн хөрөнгө

дебет: урсгал данс, бараа ба үйлчилгээ, бараа, импорт, бусад

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, ГЕГ-ын Гаалийн гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

- 2.1.2. Бэлэн мөнгө.** Бэлэн мөнгөний орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Бэлэн мөнгөний орлого

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө

оруулалт, гадаадаас орсон, хувь нийлүүлсэн хөрөнгө

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Бэлэн мөнгөний зарлага

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон, хувь нийлүүлсэн хөрөнгө

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, ГЕГ-ын Гаалийн гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

2.2. Орлогын дахин хөрөнгө оруулалт.

Хөрөнгө оруулалтанд буцааж оруулсан орлогын бичилтийг дараах байдлаар хийнэ. Үүнд:

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон шууд хөрөнгө оруулалт, орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого

дебет: урсгал данс, орлого, орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа, санхүүгийн тайлан нь зээлийн хүүгийн орлого, зарлагын бичилт.

2.3. Бусад хөрөнгө. 100 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай компани, түүний салбар, харъяа нэгжээ байгуулах зорилгоор гадаадаас орсон хөрөнгийг бүртгэнэ.

Бусад хөрөнгийн орлого

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон, бусад хөрөнгө

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Бусад хөрөнгийн зарлага

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадагшаа гарсан, бусад хөрөнгө

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, ГЕГ-ын Гаалийн гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

- б. Санхүүгийн хөрөнгө оруулалт.** Санхүүгийн хөрөнгө оруулалт гэж хувьцаа, бонд, үнэт цаас, өрийн бичиг, мөнгөний захын хэрэгсэл болон санхүүгийн деривативуудад байршуулсан хөрөнгө оруулалтыг хэлнэ. Санхүүгийн хөрөнгө оруулалтын гүйлгээг хөрөнгийн хувьцаа болон өрийн бичиг гэсэн 2 үндсэн төрлөөр, эдийн засгийн дөрвөн бүлгээр (Төв банк, засгийн газар, арилжааны банк ба аж ахуйн нэгж) тус тусад нь бүртгэнэ. Актив данс нь харьяат бусаас авах авлагыг пассив нь харьяат бусад төлөх өглөгийг харуулна.

1. Актив.

- 1.1. Хөрөнгийн хувьцаа.** Гадаадын захаар дамжуулж харьяат бусын гаргасан хувьцаанд байршуулсан хөрөнгийн өөрчлөлтийг харуулах бөгөөд хөрөнгийн өсөлтийг активын дебет бичилтээр, хөрөнгийн бууралтыг активын кредит бичилтээр харуулна. Харин харьяатын гаргасан хувьцааг Монгол Улс дахь санхүүгийн захаар дамжуулж харьяат бус худалдан авсан тохиолдолд пассив талд өглөг хэлбэрээр бүртгэж, өсөлтийг пассивын кредит бичилтээр, бууралтыг пассивын дебет бичилтээр харуулна.

Цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" гэсэн бүлэгт хөрөнгийн хувьцааны авлага нэмэгдэхэд бусад гүйлгээний хамт шууд тусгагдах тул Засгийн газар, Монголбанкны кредит бичилтийг хийхгүй. Цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" бүлэгт бусад гүйлгээний хамт хөрөнгийн хувьцааны авлага буурахад шууд тусгагдах тул Засгийн газар, Монголбанкны дебет бичилтийг мөн хийхгүй. Хөрөнгийн хувьцааны авлага нэмэгдэх болон буурахад дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Хөрөнгийн хувьцааны авлага нэмэгдэхэд

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, актив, хөрөнгийн хувьцаа

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Хөрөнгийн хувьцааны авлага буурахад

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, актив, хөрөнгийн хувьцаа

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

- 1.2. Өрийн бичиг.** Харьяат, харьяат бусын хооронд хийсэн урт хугацааны бонд, үнэт цаас, өрийн бичиг, богино хугацааны

мөнгөний захын хэрэгслэл болон санхүүгийн деривативуудын гүйлгээг энд бүртгэнэ. Тухайн улирлын эцэст харьяат бусаас авах авлагын нэмэгдсэн өөрчлөлтийг активын дебет бичилтээр, авлагын буурсан өөрчлөлтийг активын кредит бичилтээр тус тус харуулна. Харин харьяат бусд өгөх өглөгийн нэмэгдсэн өөрчлөлтийг пассивын кредит бичилтээр, буурсан өөрчлөлтийг пассивын дебет бичилтээр бүртгэнэ.

Цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" гэсэн бүлэгт өрийн бичгийн авлага нэмэгдэхэд бусад гүйлгээний хамт кредит бичилт хийх тул Засгийн газар, Монголбанкны кредит бичилтийг хийхгүй. Цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" гэсэн бүлэгт бусад гүйлгээний хамт өрийн бичгийн авлага буурахад дебет бичилт шууд хийгдэх тул Засгийн газар, Монголбанкны дебет бичилтийг мөн хийхгүй. Өрийн бичгийн авлага нэмэгдэх болон буурахад дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Өрийн бичгийн авлага нэмэгдэхэд

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, актив, өрийн бичиг
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Өрийн бичгийн авлага буурахад

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, актив, өрийн бичиг
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Монголбанкны улирлын дэлгэрэнгүй тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

2. Пассив.

2.1. Хөрөнгийн хувьцаа. Хөрөнгийн хувьцааны хувьд цэвэр нөөцийн "нийт пассив, бусад пассив" гэсэн бүлэгт хөрөнгийн хувьцааны өглөг нэмэгдэхэд бусад гүйлгээний хамт дебет бичилтийг шууд хийх тул Засгийн газар, Монголбанкны дебет бичилтийг хийхгүй. Цэвэр нөөцийн "нийт пассив, бусад пассив" бүлэгт хөрөнгийн хувьцааны өглөг буурахад бусад гүйлгээний хамт кредит бичилт шууд хийгдэх тул Засгийн газар, Монголбанкны кредит бичилтийг хийхгүй. Хөрөнгийн хувьцааны өглөх нэмэгдэх болон буурахад дараах бичилтийг хийнэ.

Хөрөнгийн хувьцааны өглөг нэмэгдэхэд

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, пассив, хөрөнгийн хувьцаа
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Хөрөнгийн биржийн арилжааны мэдээ, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн нэгдсэн дансны тайлан.

Хөрөнгийн хувьцааны өглөг буурахад:

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, пассив, хөрөнгийн хувьцаа
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Хөрөнгийн биржийн арилжааны мэдээ, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн нэгдсэн дансны тайлан.

Өрийн бичиг. Өрийн бичгийн хувьд цэвэр нөөцийн "нийт пассив, бусад пассив" бүлэгт өрийн бичгийн авлага нэмэгдэхэд бусад гүйлгээний хамт дебет бичилтийг шууд хийх тул Засгийн газар, Монголбанкны дебет бичилтийг хийхгүй. Цэвэр нөөцийн "нийт пассив, бусад пассив" бүлэгт өрийн бичгийн авлага буурахад бусад гүйлгээний хамт кредит бичилт шууд хийгдэх тул Засгийн газар, Монголбанкны кредит бичилтийг хийхгүй. Өрийн бичгийн авлага нэмэгдэх болон буурахад дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Өрийн бичгийн авлага нэмэгдэхэд

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, пассив, өрийн бичиг
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, пассив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Монголбанкны улирлын дэлгэрэнгүй тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

Өрийн бичгийн авлага буурахад

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, актив, өрийн бичиг
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Монголбанкны улирлын дэлгэрэнгүй тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

- в. Бусад хөрөнгө оруулалт.** Энэ бүлэгт бүх төрлийн зээлийг (тухайлбал, арилжааны, хөнгөлөлттэй, урт хугацааны, богино хугацааны, худалдааны зээл гэх мэт) хамруулахаас гадна арилжааны банкуудын ностро харилцах, хадгаламж болон арилжааны банкууд дээр байгаа лоро харилцах, хадгаламж болон бусад актив/пассивыг хамруулна. Зээлийг

урт болон богино хугацаатай гэсэн 2 ангиллаар харуулна. Нэг хүртэлх жилийн хугацаатай зээлийг богино хугацааны, нэг ба түүнээс дээш жилийн хугацаатай зээлийг урт хугацааны зээлд бүртгэнэ.

1. Актив

1.1. Худалдааны зээл. "Худалдааны зээл" гэж экспорт, импортын төлбөртэй холбогдож нийлүүлэгч болон захиалагчийн хооронд шууд үүсэх өглөг, авлагыг хэлнэ. Тухайлбал, экспортлогч талаас олгосон мөнгөн урьдчилгаа, дараа төлбөрийг нь хүлээн авахаар нийлүүлсэн бараа, үйлчилгээ, импортлогч талаас дараа төлбөр хийх нөхцлөөр авсан бараа, үйлчилгээг энд ойлгоно. Дараа төлбөр хийх нөхцлөөр нийлүүлэгдэж буй импортын барааны мэдээллийг авахад хүндрэлтэй байхаас гадна ихэнх тохиолдолд ийм төрлийн гэрээгээр импортын барааны маш бага хэсэг хийгддэг тул төлбөрийн тэнцэлд тусад нь харуулах шаардлагагүй. Үүнтэй уялдан энэ бүлэгт зөвхөн экспорттой холбогдож үүссэн худалдааны зээлийг харуулна. Харьяатын харьяат бусд дараа төлбөрийг нь хүлээн авах нөхцлөөр нийлүүлсэн экспортын бараа, үйлчилгээг актив талд авлага болгож бүртгэнэ. Харин захиалагчаас (харьяат бусаас) хүлээн авсан экспортын урьдчилгаа төлбөрийг пассив талд бүртгэнэ.

Худалдааны зээлийн авлага нэмэгдэхэд кредит бичилт нь ГЕГ-ын гаалийн гадаад худалдааны статистикийн барааны экспортын мэдээгээр шууд хийгдэх тул кредит бичилтийг хийхгүй. Худалдааны зээлийн авлага нэмэгдэх болон буурахад дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Худалдааны зээлийн авлага нэмэгдэхэд

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, актив, худалдааны зээл

кредит: урсгал данс, бараа ба үйлчилгээ, бараа, экспорт

Худалдааны зээлийн авлага буурахад

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, актив, худалдааны зээл

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Худалдааны зээлийн мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

1.2. Зээл. Харьяат бусаас харьяат иргэд, байгууллагад олгосон зээлийг пассив талд, харьяатын харьяат бус иргэд, байгууллагад олгосон зээлийг актив талд зээлийн ашиглалт (өглөг/авлага нэмэгдэнэ) болон төлөлтөөр (өглөг/авлага буурна) нь ялгаатайгаар харуулна. Санхүүгийн лизингийн гүйлгээг энэ бүлэгт бүртгэнэ. Манай улсын гадаадаас оруулдаг онгоц, уул уурхайн өндөр өртөг бүхий машин, техникийн лизингийн

ашиглалт, төлбөрийг пассивын кредит, дебет бичилтээр бүртгэж харуулна.

Зээлийг Монголбанк, Засгийн газар, Арилжааны банк, Аж ахуйн нэгж гэж ангилж харуулна. Түүнчлэн зээлийн хугацаанаас нь хамаарч урт хугацааны, богино хугацааны гэж хуваана.

Цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" гэсэн бүлэгт зээл нь бусад гүйлгээний хамт зээлийн авлагын кредит бичилт хийгдэх тул Засгийн газар, Монголбанкны кредит бичилтийг хийхгүй. Цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" бүлэгт бусад гүйлгээний хамт зээлийн авлагын дебет бичилт шууд тавигдах тул Монголбанкны дебет бичилтийг хийхгүй.

Зээлийн авлага нэмэгдэхэд

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, актив, зээл
кредит: урсгал данс, бараа ба үйлчилгээ, бараа, экспорт

Зээлийн авлага буурахад

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, актив, зээл
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Монголбанкны улирлын дэлгэрэнгүй тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

2. Пассив

2.1. Худалдааны зээл.

Худалдааны зээлийн хувьд авлага нэмэгдэхэд ГЕГ-ын гаалийн гадаад худалдааны статистикийн барааны экспортын мэдээгээр шууд тусгагдах тул кредит бичилтийг хийхгүй. Худалдааны зээлийн өглөг нэмэгдэх болон буурахад дараах бичилт хийнэ. Үүнд:

Худалдааны зээлийн өглөг нэмэгдэхэд

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, пассив, худалдааны зээл
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Худалдааны зээлийн өглөг буурахад

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, пассив, худалдааны зээл
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Худалдааны зээлийн мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

- 2.2. Зээл.** Зээлийн хувьд цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" гэсэн бүлэгт зээлийн өглөгийн дебет бичилтийг бусад гүйлгээний хамт шууд хийх тул Засгийн газар, Монголбанкны дебет бичилт хийхгүй. Мөн ГЕГ-ын Гаалийн гадаад худалдааны барааны статистикийн мэдээгээр барааны импортод шууд тусгагдах тул лизингийн гүйлгээний дебет бичилт хийгдэхгүй. Цэвэр нөөцийн "нийт актив, бусад актив" бүлэгт бусад гүйлгээний хамт зээлийн авлагын кредит бичилт шууд хийгдэх тул Монголбанкны кредит бичилтийг мөн хийхгүй. Зээлийн өглөг нэмэгдэх болон буурахад дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Зээлийн өглөг нэмэгдэхэд

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, пассив, зээл

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Засгийн газрын гадаад зээлийн өрийн мэдээ, Монгол банкинд бүртгэсэн валютын зээлийн мэдээ, Томоохон хамтарсан аж ахуйн нэгж, арилжааны банкуудын гадаад зээлийн өрийн мэдээ, Гадаадаас авсан санхүүгийн лизингийн мэдээ, Аж ахуйн нэгжийн судалгаа.

Зээлийн өглөг буурахад

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, пассив, зээл

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр: Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан, Засгийн газрын гадаад зээлийн өрийн мэдээ, Монгол банкинд бүртгэсэн валютын зээлийн мэдээ, Томоохон хамтарсан аж ахуйн нэгж, арилжааны банкуудын гадаад зээлийн өрийн мэдээ, Гадаадаас авсан санхүүгийн лизингийн мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

- 2.3. Бэлэн мөнгө ба харилцах.** Энд арилжааны банкны ностро/лоро харилцах данс, ностро/лоро хадгаламжийн данс, банкны касст байгаа болон банкнаас гадуур гүйлгээнд байгаа бэлэн валютын гүйлгээг энд ойлгоно. Гадаадын банкинд байгаа ностро харилцах, хадгаламжийн дансны гүйлгээг дебет, кредитээр актив талд бүртгэж, харьяат бусын Монголын арилжааны банкинд нээсэн лоро харилцах, хадгаламжийн дансны гүйлгээг пассив талд дебет, кредитээр харуулна. Гүйлгээний бичилт төлбөрийн тэнцлийн бусад гүйлгээний бүртгэлийн үед хамт хийгдэнэ. Харин актив талд бэлэн валютын гүйлгээний бичилтийг нэмж хийнэ. Бэлэн валютын гүйлгээг хоёр эх сурвалжаас авна. Үүнд:

- Арилжааны банкуудын гадаад гүйлгээний тайлан,
- Банкнаас гадуур гүйлгээнд байгаа бэлэн валютын судалгаа.

2.4. Бусад актив/пассив. Олон улсын байгууллагуудад байршуулсан Монгол Улсын хувь хөрөнгийн дансны гүйлгээг бусад актив/пассивт бүртгэнэ. Актив тал дээр олон улсын байгууллагуудад байршуулсан манай хувь хөрөнгийн өөрчлөлтийг, пассив талд олон улсын байгууллагын мэдлийн хувь хөрөнгийн дансны өөрчлөлтийг харуулна.

А. Актив

Авлага нэмэгдэхэд

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, актив, бусад актив

кредит: цэвэр нөөц, нийт актив, бусад актив (бусад гүйлгээний хамт шууд тавигдах тул кредит бичилтийг хийхгүй.)

Авлага буурахад

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, актив, бусад актив

дебет: дебет талд цэвэр нөөц, нийт актив, бусад актив (Бусад гүйлгээний хамт шууд тавигдах тул дебет бичилтийг хийхгүй.)

Мэдээллийн эх үүсвэр: Олон улсын байгууллага дахь Монгол Улсын хувь хандивын хөрөнгийн мэдээ.

Б. Пассив

Өглөг нэмэгдэхэд

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, пассив, бусад пассив

кредит: цэвэр нөөц, нийт актив, бусад актив (бусад гүйлгээний хамт шууд тавигдах тул кредит бичилтийг хийхгүй.)

Өглөг буурахад

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн хөрөнгө оруулалт, пассив, бусад пассив

дебет: дебет талд цэвэр нөөц, нийт актив, бусад актив (Бусад гүйлгээний хамт шууд тавигдах тул дебет бичилтийг хийхгүй.)

Мэдээллийн эх үүсвэр: Олон улсын байгууллага дахь Монгол Улсын хувь хандивын хөрөнгийн мэдээ.

III. Цэвэр нөөцийн өөрчлөлт

"Цэвэр нөөц" гэж гадаад валютын улсын нөөцийг Олон Улсын Валютын сангийн зээлийн үлдэгдэл ба богино хугацаат гадаад пассивын дүнгээр цэвэрлэж тооцсон нөөцийг хэлнэ. Монголбанкны гадаад цэвэр нөөцийн мэдээнээс цэвэр

нөөцийн өөрчлөлтийг тооцно. Цэвэр нөөцийн өөрчлөлтийг актив ба пассивын өөрчлөлтөөр нь тусад нь салгаж харуулна.

Гадаад валютын цэвэр албан нөөцийн өөрчлөлтийг тооцоходоо ханшийн өөрчлөлт, нөөцийг бий болгохтой холбоотой гүйлгээнүүд (алтны мөнгөжүүлэлт, зээлжих тусгай эрхийг байршуулах/буцаах)-ийг төлбөрийн тэнцэлд тусгахгүй. Түүнчлэн ангиллыг дахин өөрчлөхтэй холбоотой гүйлгээнүүдийг төлбөрийн тэнцэлд оруулахгүй.

Мөнгөжсөн алтны гүйлгээнд зөвхөн бусад орны төв банкууд, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллагууд эсвэл олон улсын санхүүгийн байгууллагуудтай хийж буй мөнгөжсөн алтны гүйлгээ хамаарна.

Хүснэгт 4. Цэвэр нөөцийн өөрчлөлт

Үзүүлэлтүүд	Кредит	Дебет
III. ЦЭВЭР НӨӨЦИЙН ӨӨРЧЛӨЛТ (А-Б)		
А. Нийт активийн өөрчлөлт		
1. Мөнгөжсөн алтны өөрчлөлт	-	+
2. Бусад активын өөрчлөлт	-	+
Б. Нийт пассивийн өөрчлөлт		
1. ОУВС-гийн зээлийн өөрчлөлт	+	-
2. Бусад богино хугацааны пассивийн өөрчлөлт	+	-

Тайлбар: /+/ тэмдгээр тухайн гүйлгээний нэмэгдэх өөрчлөлт, /-/ тэмдгээр хасагдах өөрчлөлтийг тус тус тэмдэглэв.

Найм. Үндэсний тооцооны систем ба Төлбөрийн тэнцэл

Үндэсний тооцооны системтэй нягт уялдаа холбоотой эдийн засгийн нэгдсэн тооцооны нэг биеэ даасан хэсэг нь төлбөрийн тэнцэл юм. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтийг гадаад эдийн засгийн дансанд тусгана.

Үндэсний тооцооны систем нь тайлант хугацаанд хийгдэх актив, пассивын өөрчлөлт, ажил гүйлгээ, бусад урсгал, хөрөнгийн өөрчлөлтийг нэгтгэсэн байдгаараа төлбөрийн тэнцэлтэй нягт уялддаг.

Үндэсний тооцооны системийн гадаад эдийн засгийн дансны бүртгэл нь төлбөрийн тэнцлийн бичилтээр бүртгэгдэнэ.

Төлбөрийн тэнцэл нь Үндэсний тооцооны системийн нэг бүрэлдэхүүн хэсгийн хувьд түүнтэй ижил ухагдахуун бүхий ойлголтыг хэрэглэдэг. Тухайлбал, харьяат нэгж (үйлдвэрлэгч, хэрэглэгч), ажил гүйлгээ, гадаад актив, пассивын үлдэгдлийн үнэлгээ, хөрөнгө, ажил, гүйлгээг бүртгэх хугацаа, гүйлгээг хөрвүүлэх үе шат, бодит нөөцийн (бараа, үйлчилгээ, орлого) гадаад гүйлгээний хамралт болон шилжүүлэг (урсгал болон хөрөнгийн) зэргийг энд дурьдаж болно. Мөн гадаад санхүүгийн актив, пассивын талаарх ойлголтын хувьд ч ижил байна. Тухайлбал:

- Харьяат үйлдвэрлэгч, хэрэглэгчийн тодорхойлолт нь ижил утгатай байна. Энд харьяат нэгжийн эдийн нутаг дэвсгэр ба эдийн засгийн сонирхлын төв гэсэн ойлголт ижилхэн юм.
- Зах зээлийн үнэ гэсэн ойлголт ижил утгатай байна.
- Ажил, гүйлгээний бүртгэл нь аккруэл суурьт тулгуурласан байна.

- Төлбөрийн тэнцлийн ажил, гүйлгээний болон Үндэсний тооцооны системийн гадаад эдийн засгийн дансны ангилал нь ашиглах зорилгоосоо хамааран өөр байж болно.

Нийт эдийн засгийн нэгдсэн данс болон төлбөрийн тэнцлийн урсгал гүйлгээний үзүүлэлтүүдийн хоорондох уялдааг дараахь томъёогоор илэрхийлж болно.

$$\text{ДНБ} = \text{ХХ} + \text{ЗГХ} + \text{ДХО} + \text{Е} - \text{И}$$

$$\text{УТ} = \text{Е} - \text{И} + \text{ГЦО} + \text{УЦШ}$$

$$\text{ҮНЭО} = \text{ХХ} + \text{ЗГХ} + \text{ДХО} + \text{УТ}$$

$$\text{ҮНЭО} - \text{ХХ} - \text{ЗГХ} = \text{НХ}$$

$$\text{НХ} = \text{ДХО} + \text{УТ}$$

$$\text{НХ} - \text{ДХО} = \text{УТ}$$

$$\text{НХ} - \text{ДХО} + \text{ХЦШ} - \text{СБҮЦХА} = \text{САВ} + \text{ХЦШ} - \text{СБҮЦХА} = \text{ЦГХО}$$

Энд:

- ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн
- ХХ = хувийн хэрэглээний зардал
- ЗГХ = засгийн газрын хэрэглээний зардал
- ДХО = дотоодын нийт хөрөнгө оруулалт
- Е = бараа, үйлчилгээний экспорт
- И = бараа, үйлчилгээний импорт
- Е - И = төлбөрийн тэнцлийн бараа, үйлчилгээний тэнцэл
- УТ = урсгал тэнцэл буюу сальдо
- НХ = нийт хадгаламж
- ГЦО = гаднаас орж ирсэн цэвэр орлого
- УЦШ = урсгал цэвэр шилжүүлэг
- ҮНЭО = үндэсний нийт эзэмшлийн орлого
- ХЦШ = хөрөнгийн цэвэр шилжүүлэг
- СБҮЦХА = санхүүгийн бус, үйлдвэрлэдэггүй цэвэр худалдан авалт
- ЦГХО = цэвэр гадаад хөрөнгө оруулалт буюу гадаад эдийн засагдахь цэвэр зээл/цэвэр зээллэг

ХЦШ – СБҮЦХА = төлбөрийн тэнцлийн хөрөнгийн дансны тэнцэл байна.

Хүснэгт 5. Гадаад эдийн засгийн данс ба төлбөрийн тэнцлийн уялдаа

ҮТС, Гадаад эдийн засгийн данс	Төлбөрийн тэнцэл
Гадаад бараа, үйлчилгээний данс	Урсгал данс, Бараа, үйлчилгээ
Гадаад анхны орлого хувиарлалтын ба урсгал шилжүүлгийн данс	Урсгал данс, Орлого, урсгал шилжүүлэг
Гадаад хуримтлалын данс	
Хөрөнгийн данс	Хөрөнгө ба санхүүгийн данс, Хөрөнгийн данс
Санхүүгийн данс	Хөрөнгө ба санхүүгийн данс, Санхүүгийн данс

Хавсралт 1. Төлбөрийн тэнцэл, түүний стандарт үзүүлэлт

I. Урсгал данс

A. Бараа болон үйлчилгээ

а. Бараа

1. Экспорт

1.1. Зэсийн баяжмал

1.2. Мөнгөжөөгүй алт

1.3. Бусад

2. Импорт

2.1. Тусламжийн бараа

2.2. Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар
нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж

2.3. Бусад

б. Үйлчилгээ

1. Тээвэр

1.1. Зорчигч тээвэрлэлт

1.2. Ачаа тээвэрлэлт

1.3. Бусад

2. Аялал

2.1. Албан томилолт

2.2. Хувийн аялал

2.2.1. Жуулчлал

2.2.2. Сургалт

2.2.3. Эмчилгээ

2.2.4. Бусад

2.3. Бусад аялал

3. Харилцаа холбооны үйлчилгээ

4. Барилгын ажил

5. Даатгалын үйлчилгээ

6. Санхүүгийн үйлчилгээ

7. Компьютер, мэдээллийн үйлчилгээ

8. Патент, тэмдэгт, лицензийн хураамж

9. Бусад бизнесийн үйлчилгээ

10. Амралт, соёлын үйлчилгээ

11. Засгийн газрын үйлчилгээ

Б. Орлого

а. Ажиллагчдын цалин хөлс

б. Хөрөнгө оруулалтын орлого

1. Шууд хөрөнгө оруулалт

1.1. Хувь нийлүүлсэн хөрөнгөнд ногдох орлого

1.2. Зээлийн хүүний орлого

2. Санхүүгийн хөрөнгө оруулалт

2.1. Хувьцааны орлого

2.2. Зээлийн хүүний орлого

3. Бусад хөрөнгө оруулалт

В. Урсгал шилжүүлэг

а. Засгийн газрын шилжүүлэг

- б. Бусад
 - 1. Ажиллагчдын гуйвуулга
 - 2. Бусад шилжүүлэг

II. Хөрөнгө ба санхүүгийн данс

А. Хөрөнгийн данс

а. Хөрөнгийн шилжүүлэг

- 1. Засгийн газар
 - 1.1. Хүчингүй болгосон өр
 - 1.2. Газар
 - 1.3. Бусад
- 2. Бусад сектор
 - 2.1. Шилжин суугчдын шилжүүлэг
 - 2.2. Хүчингүй болгосон өр
 - 2.3. Бусад

- б. Үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус актив хөрөнгө эзэмшил/шилжүүлэг

Б. Санхүүгийн данс

а. Шууд хөрөнгө оруулалт

- 1. Гадаадад гарсан
 - 1.1. Хувь нийлүүлсэн хөрөнгө
 - 1.2. Орлогын дахин хөрөнгө оруулалт
 - 1.3. Бусад хөрөнгө
- 2. Гадаадаас орсон
 - 2.4. Хувь нийлүүлсэн хөрөнгө
 - 2.5. Орлогын дахин хөрөнгө оруулалт
 - 2.6. Бусад хөрөнгө

б. Санхүүгийн хөрөнгө оруулалт

- 1. Актив
 - 1.1. Хөрөнгийн хувьцаа
 - 1.1.1. Төв банк
 - 1.1.2. Засгийн газар
 - 1.1.3. Арилжааны банк
 - 1.1.4. Аж ахуйн нэгж
 - 1.2. Өрийн бичиг
 - 1.2.1. Төв банк
 - 1.2.2. Засгийн газар
 - 1.2.3. Арилжааны банк
 - 1.2.4. Аж ахуйн нэгж

2. Пассив

- 2.1. Хөрөнгийн хувьцаа
 - 2.1.1. Төв банк
 - 2.1.2. Засгийн газар
 - 2.1.3. Арилжааны банк
 - 2.1.4. Аж ахуйн нэгж
- 2.2. Өрийн бичиг
 - 2.2.1. Төв банк
 - 2.2.2. Засгийн газар
 - 2.2.3. Арилжааны банк
 - 2.2.4. Аж ахуйн нэгж

в. Бусад хөрөнгө оруулалт

- 1. Актив
 - 1.1. Худалдааны зээл
 - 1.2. Зээл
 - 1.2.1. Төв банк
 - 1.2.1.1. Урт хугацааны
 - 1.2.1.2. Богино хугацааны
 - 1.2.2. Засгийн газар
 - 1.2.2.1. Урт хугацааны
 - 1.2.2.2. Богино хугацааны
 - 1.2.3. Арилжааны банк
 - 1.2.3.1. Урт хугацааны
 - 1.2.3.2. Богино хугацааны
 - 1.2.4. Аж ахуйн нэгж
 - 1.2.4.1. Урт хугацааны
 - 1.2.4.2. Богино хугацааны
 - 1.3. Бэлэн мөнгө ба харилцах
 - 1.4. Бусад актив
- 2. Пассив
 - 2.1. Худалдааны зээл
 - 2.2. Зээл
 - 2.2.1. Төв банк
 - 2.2.1.1. Урт хугацааны
 - 2.2.1.2. Богино хугацааны
 - 2.2.2. Засгийн газар
 - 2.2.2.1. Урт хугацааны
 - 2.2.2.2. Богино хугацааны
 - 2.2.3. Арилжааны банк
 - 2.2.3.1. Урт хугацааны
 - 2.2.3.2. Богино хугацааны
 - 2.2.4. Аж ахуйн нэгж
 - 2.2.4.1. Урт хугацааны
 - 2.2.4.2. Богино хугацааны
 - 2.3. Бэлэн мөнгө ба харилцах
 - 2.4. Бусад пассив

III. Цэвэр нөөцийн өөрчлөлт

- А. Нийт активын өөрчлөлт
 - 1. Мөнгөжсөн алтны өөрчлөлт
 - 2. Бусад активын өөрчлөлт
- Б. Нийт пассивын өөрчлөлт
 - 1. ОУВС-гийн зээлийн өөрчлөлт
 - 2. Бусад богино хугацааны пассивын өөрчлөлт

Хавсралт 2. Төлбөрийн тэнцлийн хураангуй хүснэгт

Үзүүлэлтүүд он				
	I	II	III	IV	улирлын дүн
I. УРСГАЛ ДАНС (А+Б+В)					
А. Бараа болон үйлчилгээ (а+б)					
а. Бараа (1+2)					
1. Экспорт Ф.О.Б.					
1.1. Зэсийн баяжмал				+	
1.2. Мөнгөжөөгүй алт				+	
1.3. Бусад				+	
2. Импорт Ф.О.Б.					
б. Үйлчилгээ(1:11)					
1. Тээвэр					
2. Аялал					
2.2.1. Жуулчлал				+	-
3. Харилцаа холбооны үйлчилгээ /цэвэр/				+	-
4. Барилгын ажил /цэвэр/				+	-
5. Даатгалын үйлчилгээ /цэвэр/				+	-
6. Бусад бизнесийн үйлчилгээ				+	-
Б. Цэвэр орлого (а+б)					
а. Ажиллагчдын цалин хөлс /цэвэр/				+	-
б. Хөрөнгө оруулалтын орлого /цэвэр/				+	-
В. Урсгал шилжүүлэг (а+б)					
а. Засгийн газрын шилжүүлэг /цэвэр/				+	-
б. Бусад урсгал шилжүүлэг					
1. Ажиллагчдын гуйвуулга				+	-
1. Хүлээн авсан					
2. Шилжүүлсэн					
2. Бусад шилжүүлэг /цэвэр/				+	-
II. ХӨРӨНГӨ БА САНХҮҮГИЙН ДАНС (А+В)					
А. Хөрөнгийн данс (а+б)					
Б. Санхүүгийн данс(а+б+в)					
а. Шууд хөрөнгө оруулалт					
б. Санхүүгийн хөрөнгө оруулалт					
1. Актив					
2. Пассив					
в. Бусад хөрөнгө оруулалт					
1. Худалдааны зээл /цэвэр/				-	+
2. Зээл					
2.1. Урт хугацааны				-	+
2.1.1. Актив				-	+
2.1.1.1. Засгийн газар					
2.1.1.2. Урт хугацааны				-	+
2.1.2. Пассив				-	+
2.1.2.1. Ашиглалт					
2.1.2.1.1. Засгийн газар				-	+
2.1.2.1.2. Бусад сектор				-	+
2.1.2.2. Үндсэн өрийн төлбөр					
2.1.2.2.1. Засгийн газар				-	+
2.1.2.2.2. Бусад сектор				-	+

Үзүүлэлтүүд он				
	I	II	III	IV	улирлын дүн
2.2. Богино хугацааны зээл					
2.2.1. Актив					
2.2.2. Пассив					
2.2.2.1. Ашиглалт				+	-
2.2.2.2. Үндсэн өрийн төлбөр					
3. Бэлэн мөнгө ба харилцах /цэвэр/					
4. Бусад цэвэр актив				+	-
III. Алдаа, орхигдуулга				+	-
IV. Нийт Төлбөрийн тэнцэл (I + II + III)					
V. ЦЭВЭР НӨӨЦИЙН ӨӨРЧЛӨЛТ (А-Б-В)					
А. Мөнгөжсөн алтны өөрчлөлт					
Б. Бусад активын өөрчлөлт				-	+
В. ОУВС-гийн зээлийн өөрчлөлт				-	+

Хавсралт 3. Төлбөрийн тэнцлийг зохиоход шаардлагатай статистикийн мэдээлэл

д/д	Мэдээ ирүүлэх байгууллагын нэр	Мэдээний нэр	Ирүүлэх хугацаа	Тайлбар	Зорилго
1	Монголбанк	1. Сургалтын төрийн сангийн мэдээ	улирал бүр		Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн тодорхойлно.
		2. СВИФТ, Ройтерийн үйлчилгээний зардлын мэдээ			Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн зардлыг тодорхойлно.
		3. Гадаадын үнэт цаас, өрийн бичиг болон бондын хүүгийн орлого, санхүүгийн хэрэгслэлийн гүйлгээгээр төлсөн орлогын мэдээ			Урсгал дансны цэвэр орлогыг тодорхойлно.
		4. Гадаадын үнэт цаас, өрийн бичиг болон бондын хүүгийн орлого, санхүүгийн хэрэгслэлийн гүйлгээгээр төлсөн зардлын мэдээ			Урсгал дансны цэвэр орлогыг тодорхойлно.
		5. Гадаадад байршуулсан харилцах, хадгаламжийн хүүний орлогын мэдээ			Урсгал дансны цэвэр орлогыг тодорхойлно.
		6. Валютын зээлийн бүртгэл			Урсгал дансны цэвэр орлогыг тодорхойлно.
		7. Засгийн газрын гадаад зээлийн хүүгийн төлбөрийн мэдээ			Урсгал дансны цэвэр орлогыг тодорхойлно.
		8. Засгийн газарт Олон улсын байгууллагаас шилжүүлсэн мэдээ		Энэ мэдээг төсвийн дансны хуулганаас гүйлгээгээр нь салгаж гаргаж болно.	Урсгал дансны үйлчилгээний зардлыг тодорхойлно.
		9. Олон улсын байгуулагад төлсөн гишүүнчлэлийн төлбөрийн мэдээ			Урсгал дансны үйлчилгээний зардлыг тодорхойлно.
		10. Банк бус санхүүгийн байгууллагын гадаад гүйлгээний тайлан		Энэхүү мэдээлэл нь гадаадад ажиллаж буй Монгол иргэдийн банк бус санхүүгийн байгуулагаар дамжуулан мөнгөн гуйвуулгын хэмжээг тогтооход ашиглагдана.	Урсгал дансны үйлчилгээний зардлыг тодорхойлно.

д/д	Мэдээ ирүүлэх байгууллагын нэр	Мэдээний нэр	Ирүүлэх хугацаа	Тайлбар	Зорилго
		<p>11. Олон улсын байгууллага дахь Монгол улсын хувь хандивын хөрөнгийн мэдээ</p> <p>12. Гадаад валютын цэвэр нөөцийн мэдээ</p>			<p>Санхүүгийн дансны бусад хөрөнгө оруулалтыг тодорхойлно.</p> <p>Цэвэр нөөцийн өөрчлөлтийг тодорхойлно.</p>
		1. Гадаад гүйлгээний тайлан	сар бүр		Төлбөрийн тэнцлийн урсгал данс, хөрөнгө бө санхүүгийн дансны гүйлгээг тодорхойлно.
2	Арилжааны банкууд	2. СВИФТ, Ройтерийн үйлчилгээний зардлын мэдээ	улирал бүр		Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн зардлыг тодорхойлно.
		3. Арилжааны банкуудын гадаад зээлийн өрийн мэдээ			
3	Санхүүгийн зохицуулах хороо	Хөрөнгийн биржийн арилжааны мэдээ	улирал бүр		Санхүүгийн дансны санхүүгийн хөрөнгө оруулалтын орлогыг тодорхойлно.
4	Хөрөнгийн бирж	Хөрөнгийн биржийн арилжааны мэдээ	улирал бүр		Санхүүгийн дансны санхүүгийн хөрөнгө оруулалтын орлогыг тодорхойлно.
5	Гадаад харилцааны яам	1. Визний хураамжийн орлогын мэдээ	улирал бүр		Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.
		2. Гадаадын элчин сайдын яам, консулын газар, олон улсын байгууллагуудын суурин төлөөлөгчийн газрын Монгол улсад төлж буй зардал ба гадаад орнууд дахь Монгол улсын элчин сайдын яам, консулын газрын зардлын мэдээ			
		3. Гадаад орнуудад байгаа Монгол улсын элчин сайдын яам, консулын газар дахь орон нутгийн ажиллагчдын цалин түүнтэй адитгах орлогын мэдээ			Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн зардлыг тодорхойлно.

д/д	Мэдээ ирүүлэх байгууллагын нэр	Мэдээний нэр	Ирүүлэх хугацаа	Тайлбар	Зорилго
	4. Газрын мэдээ			Энд Монгол улс дахь гадаадын элчин сайдын яам, олон улсын байгууллагад худалдсан болон гадаад орнууд дахь Монгол Улсын элчин сайдын яамны худалдан авсан газрын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй багтаана.	Хөрөнгийн дансны хөрөнгийн шилжүүлгийг тодорхойлно.
6	Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газар	Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ	улирал бүр	Мэдээг тоног төхөөрөмж, мөнгөн хөрөнгө оруулалтаар нь ялгаатай авна.	Санхүүгийн дансны орлогыг тодорхойлно.
7	Сангийн яам	1. Визний хураамжийн орлогын мэдээ	улирал бүр		Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.
		2. Даатгалын үйлчилгээний орлогын мэдээ			Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.
		3. Гадаадын зөвлөхийн үйлчилгээний төлбөрийн мэдээ			Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн зардлыг тодорхойлно.
		4. Гадаадын элчин сайдын яам, консулын газар, олон улсын байгууллагуудын суурин төлөөлөгчийн газрын Монгол улсад төлж буй зардал ба гадаад орнууд дахь Монгол улсын элчин сайдын яам, консулын газрын зардлын мэдээ			Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн зардлыг тодорхойлно.
		5. Гадаад орнуудад байгаа Монгол улсын элчин сайдын яам, консулын газар дахь орон нутгийн ажиллагчдын цалин түүнтэй адитгах орлогын мэдээ			
		6. Гадаадын үнэт цаас, өрийн бичиг болон бондын хүүгийн орлого, санхүүгийн хэрэгслэлийн гүйлгээгээр төлсөн зардлын мэдээ			
		7. Техник тусалцааны ашиглалтын мэдээ			
					Урсгал дансны үйлчилгээний зардлыг тодорхойлно.
					Урсгал дансны үйлчилгээний зардлыг тодорхойлно.

д/д	Мэдээ ирүүлэх байгууллагын нэр	Мэдээний нэр	Ирүүлэх хугацаа	Тайлбар	Зорилго
		8. Засгийн газарт Олон улсын байгууллагаас шилжүүлсэн мэдээ 9. Олон улсын байгууллагад төлсөн гишүүнчлэлийн төлбөрийн мэдээ 10. Газрын мэдээ		Энэ мэдээг төсвийн дансны хуулганаас гүйлгээгээр нь салгаж гаргаж болно.	Урсгал дансны урсгал шилжүүлгийн орлогыг тодорхойлно. Урсгал дансны урсгал шилжүүлгийн зардлыг тодорхойлно.
		11. Засгийн газрын хүчингүй болгосон ерийн мэдээ 12. Засгийн газрын гадаад зээлийн ерийн мэдээ		Энд Монгол улс дахь гадаадын элчин сайдын яам, олон улсын байгууллагад худалдсан болон гадаад орнууд дахь Монгол Улсын элчин сайдын яамны худалдан авсан газрын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй багтаана.	Хөрөнгийн дансны хөрөнгийн шилжүүлгийг тодорхойлно.
8	Гадаад орнууд дахь Монгол Улсын элчин сайдын яамд	Визний хураамжийн орлогын мэдээ	улирал бүр		Хөрөнгийн дансны хөрөнгийн шилжүүлгийг тодорхойлно.
9	Гаалийн ерөнхий газар	1. Гаалийн статистикийн мэдээ 2. Татваргүй барааны борлуулалтын мэдээ 3. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ	сар бүр	Мэдээнд Монгол иргэдэд худалдсаг барааны борлуулалтыг оруулахгүй. Мэдээг тоног төхөөрөмж, мөнгөн хөрөнгө оруулалтаар нь ялгаатай авна.	Санхүүгийн дансны бусад хөрөнгө оруулалтыг тодорхойлно. Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно. Урсгал дансны барааны тэнцлийн экспорт, импортыг тодорхойлно. Урсгал дансны барааны тэнцлийн экспортыг тодорхойлно.
10	Татваргүй бараа борлуулах эрх бүхий компани	Татваргүй барааны борлуулалтын мэдээ	сар бүр	Мэдээнд Монгол иргэдэд худалдсан барааны борлуулалтыг оруулахгүй.	Урсгал дансны барааны тэнцлийн экспортыг тодорхойлно.
11	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	1. Гадаадад зохиосон урлаг, спортын тоглолтын орлогын мэдээ	улирал бүр		Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.

д/д	Мэдээ ирүүлэх байгууллагын нэр	Мэдээний нэр	Ирүүлэх хугацаа	Тайлбар	Зорилго
		<p>2. Гадаадад уралдаан, тэмцээний тасалбарын Монгол улсад борлогдсон борлуулалтын мэдээ</p> <p>3. Гадаадын кино студийн Монгол улсад төлсөн зураг авалтын хураамжийн мэдээ</p> <p>4. Гадаадын уралдаан тэмцээнд Монгол иргэдийн авсан шагналын мэдээ</p>			<p>Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн зардлыг тодорхойлно.</p> <p>Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.</p> <p>Урсгал дансны бусад шилжүүлгийн орлогыг тодорхойлно.</p>
12	БОАЖЯ	<p>1. Гадаадын анчдын төлсөн хураамжийн мэдээ</p> <p>2. Гадаадын жуулчдын тоо, жуулчны орлогын мэдээ</p>	улирал бүр		<p>Урсгал дансны бусад шилжүүлгийн орлогыг тодорхойлно.</p> <p>Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.</p>
13	Нийгийн хамгаалал, хөдөлмөрийн яам	Гадаадад гэрээгээр ажиллаж буй Монгол иргэдийн мэдээ	улирал бүр		Урсгал дансны урсгал шилжүүлгийн орлогыг тодорхойлно.
14	Ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтэд зуучлагч компаниуд	Гадаадад гэрээгээр ажиллаж буй Монгол иргэдийн мэдээ	улирал бүр		Урсгал дансны урсгал шилжүүлгийн орлогыг тодорхойлно.
15	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим	<p>1. Гадаадад зохиогдсон үзэсгэлэн, яармагийн зардал болон Монгол улсад зохиогдсон олон улсын үзэсгэлэн яармагийн орлогын мэдээ</p> <p>2. Арбитрын шүүхийн орлогын мэдээ</p>	улирал бүр		<p>Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлого, зардлыг тодорхойлно.</p> <p>Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.</p>
16	Хил хамгаалах ерөнхий газар	Хилээр орсон, гарсан иргэдийн мэдээ	улирал бүр	Энэхүү мэдээг гадаадын жуулчдын орлого, Монгол иргэдийн гадаадад жуулчласны зардлыг тодорхойлоход ашиглана.	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлого, зардлыг тодорхойлно.
17	Оюуны Өмчийн Газар	Оюуны өмчийн хураамж болон эрх худалдсан орлогын мэдээ	улирал бүр	Эрх ашигласны хураамжийг үйлчилгээний тэнцлийн, эрх худалдсаны орлогыг хөрөнгийн дансны тооцоонд ашиглана.	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлого болон хөрөнгийн дансны орлогыг тодорхойлно.

д/д	Мэдээ ирүүлэх байгууллагын нэр	Мэдээний нэр	Ирүүлэх хугацаа	Тайлбар	Зорилго
18	Гадаадын хөрөнгө оруулалттай компани	1. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ	улирал бүр	Мэдээг тоног төхөөрөмж, мөнгөн хөрөнгө оруулалтаар нь салгаж гарга.	Санхүүгийн дансны орлогыг тодорхойлно.
		2. Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн гадаад ажиллагчдын цалингийн мэдээ			
19	Иргэний нисэхийн ерөнхий газар	Навигацийн орлогын мэдээ	улирал бүр		Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн тодорхойлно.
20	Чингис хаан нисэх буудлын удирдах газар	Олон улсын нисэх хураамжийн мэдээ	улирал бүр		Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн тодорхойлно.
		1. Ачаа тээвэрлэлтийн мэдээ			Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн тодорхойлно.
21	Төмөр зам	2. Галт тэрэгний тийз борлуулалтын мэдээ	улирал бүр	Мэдээнд Монгол иргэд худалдан авсан тийзийн үнийг оруулахгүй.	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлого, зардлыг тодорхойлно.
		3. Боомтын үйлчилгээ ба дамжин өнгөрсний төлбөрийн мэдээ			
22	МИАТ, Аэро Монголия, бусад	1. Ачаа тээвэрлэлтийн мэдээ	улирал бүр	Мэдээнд Монгол иргэд худалдан авсан тийзийн үнийг оруулахгүй.	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлого, зардлыг тодорхойлно.
		2. Онгоцны тийз борлуулалтын мэдээ			
		3. Боомтын үйлчилгээ ба дамжин өнгөрсний төлбөрийн мэдээ			

д/д	Мэдээ ирүүлэх байгууллагын нэр	Мэдээний нэр	Ирүүлэх хугацаа	Тайлбар	Зорилго
		4. Гадаадаас авсан санхүүгийн лизингийн мэдээ			Санхүүгийн дансны бусад хөрөнгө оруулалтыг тодорхойлно.
23	Агаарын болон төмөр замын тээвэр зуучийн компани	Ачаа тээвэрлэлтийн мэдээ	улирал бүр		Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.
24	Гадаадын авиа компаниудын салбар	Онгоцны тийз борлуулалтын мэдээ	улирал бүр	Мэдээнд Монгол иргэд худалдан авсан тийзийн үнийг оруулахгүй.	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлого, зардлыг тодорхойлно.
25	Тийзний үйлчилгээ эрхэлж буй компаниуд	Онгоцны болон галт тэрэгний тийз борлуулалтын мэдээ	улирал бүр	Мэдээнд Монгол иргэд худалдан авсан тийзийн үнийг оруулахгүй.	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлого, зардлыг тодорхойлно.
26	Шуудангийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд	Илгээмжийн мэдээ	улирал бүр	Энэхүү мэдээнд гадаадад ажиллаж буй Монгол иргэдийн Монгол руу илгээсэн илгээмж болон Монгол улсад ажиллаж буй гадаадын иргэдийн гадаад орон руу илгээсэн барааны (мөнгөн бус хэлбэрийн) илгээмжийг хамруулна.	Урсгал дансны урсгал шилжүүлгийн орлого, зарлагыг тодорхойлно.
27	Хувийн гуйвуулга үйлчилгээ эрхэлдэг Банк бус санхүүгийн байгууллагууд	Банк бус санхүүгийн байгууллагын гадаад гүйлгээний тайлан	улирал бүр	Энэхүү мэдээ нь гадаадад ажиллаж буй Монгол иргэдийн Банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан мөнгөн гуйвуулгын хэмжээг тогтооход ашиглагдана.	Урсгал дансны урсгал шилжүүлгийн орлогыг тодорхойлно.
28	Экспортын бараа үйлдвэрлэгч томоохон компани	Худалдааны зээлийн мэдээ	улирал бүр		Санхүүгийн дансны бусад хөрөнгө оруулалтыг тодорхойлно.
29	Томоохон компани	Аж ахуйн нэгжийн гадаад зээлийн өрийн мэдээ	улирал бүр	Одоогоор зөвхөн томоохон компаниудын гадаадаас зээл авдгийг харгалзан үзэв.	Санхүүгийн дансны бусад хөрөнгө оруулалтыг тодорхойлно.

Хавсралт 4. Төлбөрийн тэнцлийг зохиоход шаардагдах судалгааны жагсаалт

д/д	Судалгааны нэр	Зорилго	Хамрах хүрээ	Хугацаа	Тайлбар
1	Аж ахуйн нэгжийн судалгаа	Төлбөрийн хамрагдах сайжруулна. тэнцэлд мэдээллийг	Бүх аж ахуйн нэгжүүд	Тухай бүр	
2	Олон улсын байгууллага, гадаад орнуудын засгийн газар болон бусад оршин суугч бусын зардлаар Монгол Улсад зохион байгуулагдсан хурал, семинар, зөвлөгөөний зардлын судалгаа	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.	1. Олон улсын байгууллагын салбар, суурин төлөөлөгчийн газрууд 2. Гадаадын Элчин Сайдын Яамд 3. Томоохон зочид буудлууд	7, 10 дугаар сарын эхний хагас	
3	Монгол Улсад томилолтоор ажилласан олон улсын болон гадаадын байгууллагын ажиллагчдын томилолтын зардлын судалгаа	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.	1. Олон улсын байгууллагын салбар, суурин төлөөлөгчийн газрууд 2. Гадаадын Элчин сайдын яамд 3. Томоохон зочид буудлууд	7, 10 дугаар сарын эхний хагас	
4	Монгол Улсын төрийн болон бусад байгууллагын ажиллагчдын гадаад оронд хурал, зөвлөгөөнд оролцсон, ажилласан томилолтын зардлын судалгаа	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн зардлыг тодорхойлно.	1. Сангийн яам 2. Монголбанк 3. Арилжааны банкууд 4. Томоохон компаниуд 5. Төрийн бус байгууллагууд	1, 7 дугаар сарын эхний хагас	
5	Монгол Улсад ирж буй гадаадын жуулчдын судалгаа	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.	1. БОАЖЯ-ны Аялал жуулчлалын газар 2. Аялал жуулчлал эрхэлдэг компаниуд 3. Зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд	7, 10 дугаар сарын эхний хагас	
6	Гадаад жуулчлагч Монгол иргэдийн судалгаа	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн зардлыг тодорхойлно.	1. БОАЖЯ-ны Аялал жуулчлалын газар 2. Аялал жуулчлал эрхэлдэг компаниуд 3. Хил хамгаалах ерөнхий газар	7, 10 дугаар сарын эхний хагас	Судалгаанд Хил хамгаалах ерөнхий газраас гаргадаг Монгол улсын хилээр орсон, гарсан монгол иргэдийн мэдээг нэмэлт байдлаар ашиглана.
7	Монгол Улсын их, дээд сургуулиудад суралцаж буй гадаадын оюутнуудын тоо, сургалтын төлбөрийн судалгаа	Урсгал дансны үйлчилгээний тэнцлийн орлогыг тодорхойлно.	1. Их дээд сургуулиуд	10 дугаар сарын эхний хагас	